

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл


2013. 07 сар. №13 (047)

www.mongolianeconomy.mn

Нүүрсний уналтын цэг

НӨАТ ба түүний шинэчлэл

САЛХИ БА БИЗНЕС





**ШИНЭ АМЬДРАЛД
ХАМТДАА ТЭМҮҮЛЬЕ**



8 ХУВИЙН ХҮҮТЭЙ ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙГ

БҮХ САЛБАРУУДААР ШУУРХАЙ ОЛГОЖ БАЙНА

Зээлтэй харилцагчдаа **8 хувь** руу
ШИМТГЭЛГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛЖ БАЙНА



☎ 1977 /24 цаг/

🌐 www.tdbm.mn

📘 tdbm.mn/facebook

🐦 tdbm.mn/twitter



Hospital Information Systems &
eHealth Solutions

Medical Package Solutions

Hospital Engineering &
Consulting Services

AME ИНТЭРНЭШНЛ ХХК

Hoyosgasse 5
1040 Vienna
Austria



+43 1 503 59 79
office@ame-international.com

www.ame-international.com

AME ИНТЭРНЭШНЛ ХХК

Бидний чадвар туршлага

AME Интэрнэшнл ХХК нь Австри Улсын нийслэл Вена хотод төвтэй. 1995 онд нээгдсэн цагаасаа эхлэн өөрийн түнш байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран эрүүл мэнд болон газар тариалангийн салбарт үйл ажиллагаагаа голчлон явуулж байна.

Тус компани нь нэн ялангуяа эрүүл мэндийн технологи, цахим эрүүл мэндийн систем болон газар тариалангийн салбарт технологийн төслүүдийг цогцоор төлөвлөх, зөвлөх болон үр дүнтэйгээр хэрэгжүүлэх зорилго тавин ажилладаг.

Манай компанийн санхүүгийн тогтвортой байдал мөн техникийн болон санхүүгийн түншүүдийн нягт хамтын ажиллагаатай уялдуулсан дэвшилтэт, бүтээлч, нөхцөл байдалд дасан зохицох менежментийн уян хатан арга барил зэрэг нь харилцагч үйлчлүүлэгчиддээ тогтвортой үр ашигтай үйлчилгээг үзүүлэх үндэс суурь болдог.

Бид харилцагч, бизнесийн түншүүдтэйгээ хамтран эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн салбарт орчин үеийн дэвшилтэт шинэ санаа бүхий төслүүдийг амжилттай хэрэгжүүлж ирсэн. Урт хугацааны хамтын ажиллагаагаанд чиглэсэн стратегид тулгуурлан ажилладаг арга туршлагын үр дүнд бид олон улс дахь өөрийн төлөөлөгч болон харилцагч түнш аж ахуйн нэгж байгууллагуудынхаа дунд тодорхой байр суурь нэр хүндийг хүртэж чадсан.

Одоогоор дэлхийн хэмжээнд Европын орнуудаас гадна

Зүүн өмнөд Ази, Африк болон Ойрхи Дорнодын орнуудад нийт 110 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

AME ХХК нь олон улсын чанарын удирдлагын 9001:2008 стандартын сертификаттай үйл ажиллагаагаа явуулдаг ба жил дараалан үндэсний болон олон улсын шагнал өргөмжлөлүүдийг авсан болно. Тухайлбал 2012 онд „Австрийн шилдэг экспортлогч” өргөмжлөлийг „Худалдаа”-ны салбарын ангиллаас хүртсэн.

AME ХХК Азийн орнуудад

AME ХХК нь Азийн орнуудад эрүүл мэнд болон газар тариалангийн салбарт өөрийн түнш байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран үйл ажиллагаа явуулдаг. 1996 оноос хойш нийт 70 гаруй төслийг БНХАУ, Индонез, Вьетнам, Малайз зэрэг орнуудад Австри улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр амжилттай хэрэгжүүлж ирсэн олон жилийн арвин туршлагатай.

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэлээс эхлээд Азид хамгийн анхны цаасгүй цахим эмнэлгийн технологийг нэвтрүүлэх зэрэг нийт 50 гаруй төслийг хэрэгжүүлсэн.

Мөн газар тариалангийн салбарын чиглэлээр хөрсний элэгдэл, бохирдол, эвдрэл, цөлжилтөөс сэргийлэх, хөрс хамгаалах, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, түүнчлэн тус салбар дахь орон нутгийн ажиллагсдыг газар тариалангийн орчин үеийн технологи тоног төхөөрөмж дээр дадлагашуулан сургах зорилгоор усалгаатай тариалангийн төслүүдийг хэрэгжүүлэн арвин туршлага хуримтлуулсан болно.

Ногоон хөгжлийн шлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс
ОРЧУУЛАГЧ: Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД: Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Х.Хулан

ДИЗАЙНЕР: Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Барянжав /9409-2904/
Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: М.Хишигтогтох /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ

РЕДАКТОР: Б.Үүрийнтуяа

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж глаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

“Mongolian Economy” сэтгүүлийн захиалгын үнэ

Нэг дугаарын үнэ	1	15.000₮	10\$
Улирлаар	6	90.000	60\$
Хагас жилээр	12	180.000₮	120\$
Бүтэн жилээр	24	360.000₮	240\$

Борлуулалтын үнэ: 18.000₮

Хэвлэл захиалгын компаниуд:

“Монгол шуудан” ХХК

“Улаанбаатар шуудан” ХХК

“Түгээмэл шуурхай шуудан” ХХК

“Скай шуудан” ХХК

The Morning Post

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИД ЗАХИАЛГА БАЙНГА АВНА



“Mongolian Economy” сэтгүүлийн зар, сурталчилгааны үнэ

A4 буюу сэтгүүлийн 1 нүүр	800.000₮
A3 буюу сэтгүүлийн дэлгэмэл нүүр	1.600.000₮
A5 буюу сэтгүүлийн 1/2	400.000₮
A6 буюу сэтгүүлийн 1/4	200.000₮
Сэтгүүлийн 1/3	300.000₮

Зар/төсөл, тендер, ажлын байрны зар/

A4 буюу сэтгүүлийн 1 нүүр	320.000₮
A4 хуудсын 1/2	160.000₮
A4 хуудсын 1/4	80.000₮

II-V нүүр	1.200.000₮
Хавтасны анонс	800.000₮

Б.Үнэнбат: Илүү холын мөрөөдөл бидэнд бий



Ньюком группийн гүйцэтгэх захирал Б.Үнэнбаттай ярилцлаа. Тэрээр арваад жилийн өмнө Ньюком группт нягтлан бодогчоор ажилд орж байжээ. Тэр үед Салхитын салхин паркийн төслийн судалгааны ажил дөнгөж эхэлж байж. Тэгвэл тэрбээр өнөөдөр Ньюком компанийн гүйцэтгэх захирлын хувьд Салхитын салхин цахилгаан станцын нээлтийг хийж, үйл ажиллагааг нь эхлүүлж байна.

9

Хятадын эдийн засгийн шинэчлэл



30

Баян-Айрагийн алтны уурхай ба эсэргүүцэл



34

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

- 10 Салхи ба бизнес
- 12 “Mongolian Economy” сэтгүүлийн асуулт
- 16 Б.Үнэнбат: Илүү холын мөрөөдөл бидэнд бий
- 18 Эрчим хүчний “галав юүлэх” цагаар
- 22 Тогтвортой стратеги

ЭДИЙН ЗАСАГ

- 24 НӨАТ ба түүний шинэчлэл
- 28 Чингис бонд
- 30 Хятадын эдийн засгийн шинэчлэл

УУЛУУРХАЙ

- 32 Нүүрсний уналтын цэг
- 34 Баян-Айрагийн алтны уурхай ба эсэргүүцэл

БИЗНЕС

- 38 Швейцарийн хөгжил бэлэг байгаагүй
- 42 “Apple”-ын арван нууц

МОНГОЛД

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт энэ оны эхний зургаан сарын байдлаар 4578.0 сая ам.доллар, үүнээс экспорт 1833.8 сая ам.доллар, импорт 2744.2 сая ам.долларт хүрчээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 449.3 сая ам.доллар буюу 8.9 хувь, үүний дотор экспорт 176.3 сая ам.доллар буюу 8.8 хувь, импорт 273.0 сая ам.доллар буюу 9.0 хувиар буурсан үзүүлэлт юм. Гадаад худалдааны тэнцэл энэ оны эхний зургаан сарын байдлаар 910.4 сая ам.долларын алдагдалтай гарч өмнөх оны мөн үеийнхээс 96.7 сая ам.доллар буюу 9.6 хувиар буурчээ.



БНХАУ-ын Шанхай хотод долоодугаар сарын 17-19-ны хооронд сав баглаа, боодол тоног төхөөрөмжийн 19 дэх удаагийн олон улсын “Pro Pak China 2013” үзэсгэлэн болох гэж байна. Тус үзэсгэлэнд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим / МҮХАҮТ/ нь холбогдох дотоодын байгууллага аж ахуйн нэгжүүдийг оролцуулах юм. Тус үзэсгэлэнд бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол болон хуванцар, шилэн, картон зэрэг олон төрлийн

материалаар хийгдэх тоног төхөөрөмж тавигдах аж.



Ипотекийн зээлийн санхүүжилтээс өмнө олгосон 587.1 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлэх хүсэлт арилжааны банкуудад иржээ. Үүнээс банкууд 7002 иргэний хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, орон сууцны ипотекийн 195.2 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлж, зээлийн хүүг найман хувьд шилжүүлсэн байна. Иргэд 90.9 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр авах хүсэлт гаргаснаас банкууд 207 иргэнд 8.8 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгоод байна.

Ашигт малтмалын томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орж байгаатай холбоотойгоор манай улсын экспортын хэмжээ импортынхоос хурдацтай өсөхөөр байна. Тухайлбал, манай улсын экспортын хэмжээ энэ онд 43.4 хувь, 2014 онд 18.4 хувиар тус тус өсөхөөр байгаа бөгөөд импортын хэмжээ энэ хугацаанд тогтвортой 11.2 хувиар өсөхөөр байна. Ингэснээр 2013 оноос манай улсын гадаад худалдаа 1.7-2.4 тэрбум ам.долларын ашигтай гарах таатай төлөв байгаа талаар Монгол улсын эдийн

засгийн хөгжил, цаашдын чиг хандлага судалгаанд дурджээ.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл энэ оны эхний таван сард 872.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 16.4 тэрбум төгрөгөөр өсчээ. Тус өсөлтөд уул уурхай, барилгын материал, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 26.2 хувиас хоёр дахин, боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 6.5 дахин нэмэгдсэн нь нөлөөлсөн аж. Харин борлуулсан бүтээгдэхүүн энэ оны эхний таван сард 2349.8 тэрбум төгрөг болсны 59.7 хувь буюу 1403.2 тэрбум төгрөгийг гадаад зах зээлд борлуулжээ.

Таван толгойн нүүрсний уурхайг түшиглэн гаалийн хяналтын бүс байгуулахаар урьдчилсан судалгаа хийхээр болжээ. Тус судалгааны дүнд байгаль орчин, хүнд

учруулж буй хор хохирлыг бууруулах, нөгөөтэйгүүр төрийн өмчит компанийн үйл ажиллагааны зардлыг хэмнэх аж. “Эрдэнэс Тавантолгой” компани ирэх гурван жилд Цагаан хадны гаалийн бүсэд нүүрс ачиж, буулгахад 68.8 тэрбум төгрөг зарцуулахаар байгаа. Хэрвээ гаалийн хяналтын бүс байгуулбал жилдээ ердөө 4.5 тэрбум төгрөгийн урсгал зардал гарна гэж тооцжээ.

Хөгжлийн банк “Гудамж” төсөлд 200 сая ам.долларын санхүүжилт олгохоос 7.3 тэрбум төгрөгийг олгоод байна. Тус төслийн хүрээнд нийслэлийн авто замын 33 уулзварыг дөрвөн замын уулзвар болгон шинэчилж, Туул, Сэлбэ голын даланг дагуулан хурдны зам барих юм. Хөгжлийн банкнаас одоогоор “Шинэ төмөр зам” төсөлд 83.3 сая ам.доллар, “Тавантолгойн цахилгаан станц”-д 1.9 сая ам.долларыг эхний шатанд шилжүүлээд байна.



ДЭЛХИЙ ДАХИНД

БНХАУ-ын хувьцааны зах зээл огцом унаж байгаа нь тус улсын Төвбанк бага хүүтэй зээл цаашид олгохгүй гэсэнтэй холбоотой аж. Үүний улмаас Шанхайн SSE индекс таван хувиар буурч, 1965 болж, сүүлийн 52 долоо хоногт хүрсэн дээд түвшингээс 1,500 оноогоор буурсан бол CSI300 индекс зургаан хувиар буурч, 2170 болжээ. Хувьцаа арилжаалагчид тус улсад хөрвөх чадвар сайн хэвээр гэж үзсэн тул Ардын банкны энэ үйлдэлд дургүйцэх болжээ.

ОХУ-ын төрийн өмчит “Роснефть” газрын тосны компани БНХАУ руу хийх нийлүүлэлтээ хоёр дахин нэмж, 270 тэрбум ам.долларын гэрээ байгууллаа. Гэрээний дагуу хойд хөрш 2015 оноос эхлэн урд хөрш рүү өдөрт 300 мянган баррель нефть нийлүүлэх аж. Дэлхийн газрын тосны хамгийн том үйлдвэрлэгч ийнхүү Европт биш, харин ирээдүйн бизнесийн гол түнш болох Ази руу анхаарах болов.

АНУ-ын Конгрессийн төсвийн газар хэрэв тус улс санхүүгийн “ангал” руу унавал эдийн засаг нь 600 тэрбум ам.долларын алдагдал хүлээж, дахин хямралын байдалд орно гэж үзэж байна. Харин эдийн засгийн шинжээчид, мөнгөний менежерүүд энэ нь АНУ-д тулгарах олон сорилтын эхнийх нь гэжээ. Хямралаас үүдэн тус улсын эдийн засгийн өсөлт ирэх онд удаашралтай

хэвээр байх шинжтэй байна.

ОУВС-гийн Дэлхийн эдийн засгийн төлөвийн 2013 оны тайланд дэлхийн эдийн засаг гурван шатлалтай сэргэлт рүү шилжсэн болохыг харуулжээ. Хөгжиж буй орнуудын эдийн засаг хурдацтай сэргэж байгаа ч өндөр хөгжилтэй орнуудын хувьд сэргэлт тааруухан байгаа гэжээ. Хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийн таамаг энэ онд 5.3, ирэх онд 5.7 хувьтай байх бол АНУ-ын эдийн засгийн өсөлт энэ онд хоёр хувь, евробүсийн эдийн засгийн өсөлт ирэх онд 1.1 хувьтай байна гэж тус тус таамагласан байна.

“Samsung” компани Windows 8 болон Андроид үйлдлийн систем хослуулсан таблет гаргажээ. Ativ Q хэмээх энэ загвар нь 13.3 инч буюу 33.8 см-ийн дэлгэцтэй бөгөөд гарыг нь дэлгээд зөөврийн компьютер шиг ашиглахын зэрэгцээ зураг зурж, бичдэг харандаатай аж. Үүнээс хоёрхон долоо хоногийн өмнө “Asus” компани өөрийн зөөврийн компьютер болон таблет хосолсон загвараа гаргасан бөгөөд мөн л Microsoft болон Google-ийн үйлдлийн системийг хослуулжээ.

“G8” буюу дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй

найман орны лидерүүдийн уулзалт Умард Ирландад болж, татвараас зайлсхийх үйлдэлтэй тэмцэх хатуу байр сууриа лидерүүд илэрхийлж, тууштай тэмцэх амлалтаа өгөв. Арван заалтаас бүрдсэн “Lough Erne-ийн Тунхаглал” төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд үүгээрээ татвараас зайлсхийлтээс урьдчилан сэргийлэхийн тулд татварын байгууллагууд холбогдох мэдээллээ солилцож, ил тод байдлыг сайжруулахыг уриалжээ. Уг төлөвлөгөөнд улс, орнуудын хоорондох чөлөөт худалдааг дэмжиж, хүнд суртлыг арилгахад чиглэсэн заалтууд мөн багтсан байна. ■

А.АМАРСАЙХАНЫ БУЛАН



Шог зургийг А.Амарсайхан



110 YEARS

FORD EVEREST • FORD RAPTOR • FORD F-250 • FORD EXPEDITION • FORD RANGER • FORD EXPLORER • FORD TRANSIT • FORD FUSION



ӨВ УЛАМЖЛАЛЫН САР
06.12-07.15



МОНГОЛ ДАХЬ АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТОР

ВАГНЕР АЗИ АВТОМОТИВ ХХК

Нарны зам 55/1, Тээвэрчдийн гудамж, 14253, Сүхбаатар дүүрэг

Утас: 99108368, 99108303, 99118375, 99118301

www.waa.mn




ӨВ УЛАМЖЛАЛЫН САР
06.12-07.15



1903

Алдарт зохион бүтээгч, бизнесмен Хенри Форд "Ford Model A" загвараа үйлдвэрлэж Форд Моторс компанийг үүсгэн байгуулав.



FORD RANGER



~~59,000,000₮~~
54,000,000₮

FORD TRANSIT



~~56,000,000₮~~
51,000,000₮

FORD F-250



~~98,000,000₮~~
88,000,000₮

FORD EVEREST



~~60,000,000₮~~
55,000,000₮

FORD RAPTOR



~~108,000,000₮~~
103,000,000₮

FORD FUSION



~~65,000,000₮~~
63,000,000₮

FORD EXPEDITION



~~111,000,000₮~~
101,000,000₮

FORD EXPLORER



~~80,000,000₮~~
70,000,000₮

MINING RANGER



~~65,000,000₮~~
60,000,000₮

MINING EVEREST



~~67,000,000₮~~
62,000,000₮

ОЙН ОНЦГОЙ ХЯМДРАЛ

5,000,000-10,000,000₮

БИЕ ДААСАН ЛИЗИНГИЙН ВЙЛЧИЛГЭЭ:

УРЬДЧИЛГАА: 30% САРЫН ХВВ: 1.5% ХУГАЦАА: 12 сар

ЦЭВЭР ЭРЧИМ ХҮЧ

САЛХИ БА БИЗНЕС



Салхит салхин станцын тууз хайчлах ёслол

ЭЗӨРИГТ

Зуны сар дундаа орж, ногооны үнэр хамар цоргиж, нарны халуун төөнөх нь урин цагийн жаргалан гэлтэй. Малын хөлөөс өөр мөр гараагүй гэмээр онгон дагшин Төв аймгийн Сэргэлэн сумын “Салхит” уулын энгэрээр машины дохио хангинаж, уул толгодын оройгоор хүмүүсийн цуваа тасрахгүй үргэлжлэх нь ямар нэгэн баярт үйл явдал болох гэж буйг илтгэнэ. Монгол Улсын эрчим хүчний салбарт сүүлийн 30 жилд хийгдээгүй том бүтээн байгуулалт болох “Clean energy” компанийн “Салхит” салхин цахилгаан станцын нээлтийн үйл ажиллагаа болох гэж буй нь энэ юм. Нэг уулын орой, нөгөө уулын энгэрт байрлах 31 аварга салхин сэнс содон харагдана.

“Урьхан хонгор салхинд нь, Уулын модод ганхдаг билээ, Уяхан гол шиг хүүтэйгээ, Удах тусмаа дасдаг л билээ дээ” хэмээн “Урьхан хонгор салхи” монгол ардын айзам уртын дуу уянгалахтай зэрэгцэн саяхан тогтуун байсан тэнгэрт үл хуран салхи сэвэлзэж эхэллээ. Гэхдээ салхи сэвэлзэхэд баярласан хүн олон. Учир нь монголчууд салхийг эрхшээх

түүхт өдөр учраас тэр. Салхит уулнаа уригдсан зочид алга ташиж, тууз хайчлах мөчид аварга томс сэнснүүд салхины хурдаар эргэж эхлэхэд борооны мөнгөн дусал газар дэлхийг чийглэлээ.

Тэнгэр хүртэл баярын нулимс унагасан энэ том бүтээн байгуулалт эхлэх хүртэл багагүй хугацааг үджээ. Ньюком группын ТУЗ-ийн дарга Ц.Болдбаатар Монгол Улсын нутаг дэвсгэрийн салхин эрчим хүчний атласыг анх олж харснаар салхин парк байгуулах санаа төрсөн байна. Харин салхины нөөцийн судалгааг 2004 оны тэр үеэс эхлүүлжээ. Тухайн үед сэргээгдэх эрчим хүчний талаар маруухан ойлголттой байсан монголчуудын хувьд салхин парктэй болно гэдэг бүтэшгүй мөрөөдөл байсан гэдэг. Ньюком гурпын ТУЗ-ийн гишүүн Р.Арвинцогт “Монголчууд нүүрсний арвин нөөцтэй. Гэтэл яагаад бүрэн ашиглаж чадахгүй байна вэ гэдэг. Үүнтэй яг адилхан асар их хэмжээний салхины буюу сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй мөртлөө яагаад түүнийгээ бүрэн ашиглаж болохгүй гэдэг бодол

бидэнд төрсөн. Бид энэ ажлыг эхлүүлж байхад хууль эрх зүйн орчин сайн бүрдээгүй байсан. Бизнесийн хувьд ашигтай төсөл байгаагүй. Гэхдээ зөвхөн санхүүгийн үр ашиг харж ажил хийж болохгүй. Хамгийн чухал нь итгэл үнэмшил, хүсэл мөрөөдөл. Тиймээс манай хамт олон нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх, цаашлаад сэргээгдэх эрчим хүчний салбарт хүч үзэх бусад хувийн хэвшлийнхэнд үлгэр дууриал болж, итгэл өгөхөд энэхүү бүтээн байгуулалтын гол утга оршино” гэсэн юм. Тус бүтээн байгуулалтын бэлтгэл ажил 2011 оноос эхэлсэн бол үндсэн барилга угсралтын ажил өнгөрсөн оноос шуударчээ. Гэсэн хэдий ч энэ төсөл бизнесийн утгаараа ашгаа өгөх л хэрэгтэй. Хэрвээ өгөхгүй бол дараа дараагийн сэргээгдэх эрчим хүчний төсөл урагшаа явахгүй. Учир нь хувийн хэвшил улсад эрчим хүч нийлүүлж чадах уу, үгүй юу гэдгийг тодорхой болгох гол хүч бол ашиг. Тус бүтээн байгуулалтыг хийхэд 170 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орсон бөгөөд Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Голландын хөгжлийн ▶

▶ банк, “Женерал Электрик”, “Ньюком” компаниудас хөрөнгийн эх үүсвэрийг гаргажээ. Хөрөнгө оруулалтын зардлаа 15 жилийн дотор нөхөхөөр тооцсон байна. Хэдийгээр урт хугацаа ч дэлхий даяараа сэргээгдэх эрчим хүчийг хэрэглэхгүй бол тогтвортой хөгжилд хүрэхгүй гэдэг нь тодорхой энэ үед эрт орой хэзээ нэгэн цагт хүч үзэх нь ойлгомжтой зах зээлийн хаалгыг нээж өгсөн нькомчуудад талархах нь зүйтэй.

Сэргээгдэх эрчим хүч 100.000-ын тоонд дуртай

Өмнө нь нарны эрчим хүчээр 100.000 малчин өрх гэрэл цахилгаантай залгасан. Энэ удаагийн салхин станц нь 14000 га газрыг хамрах бөгөөд 50 МВт буюу мөн л 100 мянган өрхийн эрчим хүчний хэрэглээг хангах хүчин чадалтай. Эрчим хүчний сайд М.Сономпил “Өмнө нь нарны эрчим хүчний гайхамшгийг бид мэдэрсэн. Харин энэ удаа монгол хүн өөрөө судалгааг нь хийж, зураг төслийг нь гаргаж, хөрөнгө босгож энэ том бүтээн байгуулалтыг сүндэрлүүлсэн нь хувийн хэвшил болоод эрчим хүчний салбарт маш том итгэл авчирсан хэрэг боллоо” хэмээн онцолсон юм. Сүүлийн 30

тулд 240 шоо метр буюу есөн давхар байшингийн сууринд орох хэмжээний бетон зуурмаг орсон гэнэ. Мөн 110 кВт-ын 28 км урт хоёр хэлхээт дамжуулах шугам, тус бүр нь 1.6 мВт-ын чадалтай 31 салхин цахилгаан үүсгүүрээс салхит станц бүрдэнэ. Салхин сэнсүүдийг холбосон сайжруулсан шороон 33 км зам тавьсан аж. Бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгчээр Лейтон ХХК ажилласан бөгөөд дотоодын барилга угсралт, инженерийн 18 компани оролцсон байна. Барилга угсралтын ажлын оргил үед төслийн талбайд 500 гаруй хүн ажилласны 94 хувь нь монгол ажилчид. Түүнчлэн төслийн талбайд бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд 1300 гаруй км замаар тээвэрлэлт хийсэн бөгөөд 600 орчим машин оролцжээ. Хятад улсын хилээс Төв аймгийн Сэргэлэн сумын Салхит уул хүртэл шороон замаар салхин цахилгаан үүсгүүрийн эд анги болон тоног төхөөрөмжүүдийг хүнд даацын машинаар тээвэрлэхдээ гэмтээж болзошгүй эрсдлээс хамгаалж 10-15 км/цаг хурдтайгаар явжээ.

Ногоон сэнс

Утаат Улаанбаатар хотын



гаруй жилд төвийн бүсийн сүлжээнд холбогдож байгаа анхны сэргээгдэх эрчим хүчний энэхүү эх үүсвэр нь хүчин чадлаараа ДЦС-4, ДЦС-3-ын дараа орох аж.

Салхин сэнс тооны хэлээр

“Салхит” салхин цахилгаан станцын салхин сэнс нь 120 гаруй метр өндөр. Баганы өндөр нь л гэхэд 80 метр, 125 тонн жинтэй бол далбаа тус бүр нь 40 гаруй метр урт, 6.2 тонн жинтэй. Энэ аварга төхөөрөмжийг тогтоохын

нэгээхэн хэсгийг утаагүй салхин станц гэрэл цахилгаанаар хангах нь энэ зууны монголчуудын хийсэн хамгийн том эко бүтээн байгуулалт. Дэлхий дахинаа тулгамдаж байгаа асуудлын нэг бол

уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хүн амын ядуурал, байгаль орчны доройтол болоод байгаа. Энэ бүгдээс гарах гарц нь сэргээгдэх эрчим хүч. Тухайлбал, ядуурлыг эдийн засгийн ба араншлын /сэтгэлгээний ядуурал/ гэж хоёр хуваадаг аж. Эдийн засгийн ядуурал нь тухайн орны төр, засгаас баталсан орлогын доод хэмжээ болон байгаль орчны доройтлолтой холбоотой байдаг гэдэг. Харин байгаль орчны доройтол хүрэн эдийн засгаас үүсдэг. Араншлын ядуурлын талаар Америкийн эрдэмтэн Роберт Ректор “Араншлын ядуурал нь арчаагүй байдал, ажлын ёс зүйн доройтол, мэдэж сурах тэмүүллийн хомсдол, үр хүүхдээ асран хүмүүжүүлэх хүсэлгүй буюу чадваргүй байдал, гэмт хэрэг, архины дон гэх мэт нийгмийн гаж тогтолцооны багц” гэсэн байна. Хүн эдийн засгийн ядууралд хэт удаан байх нь аяндаа араншлын ядууралд хүргэдэг гэнэ. Араншлын ядуурлын хувьд хүний оюун ухаан мэдээллээр дутагдахад үүсдэг байна. Хүн мэдээллийг цуглуулж түүнийгээ боловсруулснаар мэдлэгийг бий болгодог аж. Тэгвэл мэдээллийг олж авах анхдагч хэрэглээ бүхэн гэрэл цахилгаантай холбоотой. Тэр утгаараа сэргээгдэх эрчим хүч нь олон талын ач холбогдолтой. БОНХ-ийн сайд С.Оюун “Монголын ногоон тодотголтой хамгийн том бүтээн байгуулалт бол энэ салхин станц боллоо. Цаашдаа ч энэ төрлийн бүтээн байгуулалтыг дэмжиж ажиллах нь дэлхийн дулаарал, байгаль орчны сөрөг нөлөөг бууруулах зөв арга” гэсэн юм. Станц бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр жилд 120 мянган тонн нүүрс, 1.6 сая тонн ус хэмнэх бөгөөд 20 орчим мянган га газар мод тарьсантай дүйцэхүйц хүлэмжийн хийн ялгарлаас сэргийлэх ажээ. Мөн дээр дурдсанчлан ядуурлыг бууруулахад ч хувь нэмрээ оруулах ногоон бүтээн байгуулалт юм. ■

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ**-Монголын анхны салхин станц ашиглалтад орлоо. Та сэтгэгдлээсээ хуваалцана уу?****550 МВт-ын хүчин чадал бүхий нар, салхины станц барих лицензүүд олгогдсон**

-Шинэчлэлийн Засгийн газар энэ дөрвөн жилийн мөрийн хөтөлбөртөө сэргээгдэх эрчим хүчийг түлхүү дэмжиж ажиллахаар тусгасан. Цаашдаа Сэргээгдэх эрчим хүчний салбарт бүтээн байгуулалт хийх компаниудад тодорхой хөнгөлөлт, урамшууллын тогтолцоо бий болгох үүднээс салбарын хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар манай яам бэлтгэж байна.

Нийтдээ 550 МВт-ын хүчин чадал бүхий нар салхины станц барих лицензүүд өнөөдөр олгогдсон байгаа.

Сэргээгдэх эрчим хүчний 2007 онд баталсан хуулиар цэвэр эрчим хүчний өртөг нь нэлээд өндөр. Гэхдээ айл өрхүүдэд энэ өндөр өртөг тусахгүй. Засгийн газраас үнийг тэгшитгэх зорилгоор сэргээгдэх эрчим хүчний сангаас зөрүү мөнгийг төлж байгаа.

М.Сономпил /Эрчим хүчний сайд/**Гол хүндрэл нь логистик байсан**

-Бид энэ төсөл дээр олон түнштэй хамтран гурван жилийн турш хөдөлмөрлөсөн. Багийн ажиллагаа л байлаа даа. Энэ төслийн хүрээнд учирсан хүндрэл нь логистик. Монголын өвөл их хэцүү байлаа. Тиймээс өндөр цамхаг, сэнсийг зөөх тэр дундаа Төв аймгийн Сэргэлэн сум хүртэл тээвэрлэж, угсарч суулгах, сүлжээнд холбох зэрэг ажил том сорилт болсон. Гэсэн ч багаараа даван туулж чадлаа. Монголд нийлүүлсэн бүтээгдэхүүнээ бид олон оронд ашигладаг. Монголын

салхины эрчинд нэг бүр нь 1.6 мегаваттын хүчин чадалтай салхин сэнс хамгийн тохирсон бөгөөд өгөөжтэй юм. Өөрөөр хэлбэл, Монголын нөхцөлд тохирсон бүтээгдэхүүн гэсэн үг. Бидний зүгээс дээрх сэнсүүдийн ашиглалтын 25 жилд засвар үйлчилгээг нь хариуцаж, төлөвлөсөн таван хувийн бүтээмжээ гаргаж буй эсэхт хяналт тавьж ажиллана. Цаашид Монгол Улсын хувьд бидэнд сонирхож буй өөр төслүүд бий.

Шэйнэ Фицсимонс /Женерал Электрик компанийн Санхүү хариуцсан захирал/**Ногоон тодотголтой салхин станцыг монголчууд үндсэндээ барьж байгууллаа**

-Бидний хамгийн том амжилт бол салхин цахилгаан станцид мөрдөгдөх стандартыг бий болгож, батлуулсан явдал юм. Салхитын салхин цахилгаан станцыг барьснаар утаа гаргахгүй, нүүрс шатаахгүй, нэг ч литр ус хэрэглэхгүйгээр эрчим хүч үйлдвэрлэнэ. Ногоон тодотголтой салхин станцыг монголчууд үндсэндээ барьж байгууллаа. Нийтдээ 120 сая гаруй ам.долларын

хөрөнгө оруулалт орсон томоохон бүтээн байгуулалт. Монгол Улс салхины эрчим хүчний нөөцөө ашиглаад жилд дөрвөн триллион кВт/цаг үйлдвэрлэх боломжтойг тогтоосон. Үүнээс хамгийн боломжтой хэлбэрээр нь салхин цахилгаан станц баривал 2.8 триллион кВт/цаг байгаа юм. Тиймээс бидэнд асар их боломж байна гэсэн үг. “Салхит” салхин станц бол энэ бүгдийн эхлэл.

Ц.Сүхбаатар /“Clean Energy” компанийн үйл ажиллагаа хариуцсан захирал/**Сэргээгдэх эрчим хүч бол ирээдүй**

-Монголын анхны салхин парк хувийн хөрөнгө оруулалтаар бүтлээ. Улсын дэд бүтцэд зориулж буй хувийн хэвшлийн их хэмжээний мөнгө. Оролцогч бүх талын хувьд энэ бол бахархмаар үйл явдал. Хорт хаягдал, хүлэмжийн хийн аюулаас зайлсхийхийн тулд сэргээгдэх эрчим хүч маш чухал. Монгол Улс хатуу түлш, нүүрснээс ихээхэн хамааралтай. Салхиар эрчим хүчнийхээ салбарыг төрөлжүүлчихвэл хатуу түлшний үнийн дарамт

байгаль орчин, эрчим хүчний салбарын эрсдэлийг багасгаж болно. Хорт хаягдлаа дийлэхгүй байгаа өнөөгийн нөхцөлд дэлхий хүссэн, хүсээгүй урт хугацаанд сэргээгдэх эрчим хүчээр замнахаас өөр арга байхгүй. Сэргээгдэх эрчим хүч бол ирээдүй. Бидний хувьд Монголын сэргээгдэх эрчим хүчний салбарт хамтран ажиллахад үргэлж бэлэн. Бид төслийн эхний шатны хөгжлийн санхүүжилтийг хийж, хамтран ажиллалаа.

Аарт Мулдер /Нидерландын Хөгжлийн банкны Эрчим хүч хариуцсан захирал/: ➔

► Өндөр үнэтэй гэж шууд хэлж болохгүй

-2007 онд Монгол Улс Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль баталсан. Цэвэр эрчим хүчийг дэмжихэд хөрөнгө оруулалтын орчин, үнэ гээд олон зүйлийг уг хуулиар тодорхой болгож өгсөн. Ньюком групп ч мөн адил энэ үеэр салхин цахилгаан станц барих эрхээ авч байсан. Харин өнөөдөр энэ том бүтээн байгуулалтын нээлтийн ёслол болж байгаад баяртай байна. Зохицуулах хорооны хувьд үнэ болон цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах загварыг баталж өгдөг.

Салхит салхин паркийн хувьд анхных гэдэг утгаараа худалдан авах гэрээг байгуулахад олон хүндрэл, бэрхшээл гарсан. Гэхдээ сайн багийн хүчинд асуудлыг шийдэж чадсан. Өнөөдрийн байдлаар салхин паркаас гарсан нэг кВт цахилгааныг 9.5 центээр борлуулахаар байгаа. Энэ бол харьцангуй өндөр үнэ. Гэхдээ байгаль орчинд халгүй гэдэг утгаараа эдийн засгийн болоод байгаль орчны хувьд томоохон хөрөнгө оруулалт болох учраас өндөр үнэтэй гэж шууд хэлж болохгүй юм.

Н.Мягмарсүрэн /Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч/

Ирэх өвлийн хүйтэнд сэнс хэрхэн эргэхээс олон зүйл мэдэгдэнэ

-Улаанбаатар хотын агаарын бохирдол дордож буйг харж байна. Харин бидний хувьд салхин сэнс ашиглан цэвэр эрчим хүч үйлдвэрлэж буй учир энэ бохирдлыг багасгахад туслаж чадна. Өнөөдөр зөвхөн эхний алхмаа хийлээ.

Олон бэрхшээлтэй нүүр тулсан. Салхин сэнсний бүрэлдэхүүн хэсгүүдийг зөөж авчрах л төслийн хамгийн хэцүү хэсэг байлаа. Нэг бүр нь 20-50 тоннын жинтэй салхин сэнсийг Хятадын хилээр оруулж ирж, 400 км зайд ачааны машинаар маш бага хурдаар хэдэн өдөр явж ирсэн. Олон эвдрэл тэр дундаа сэнснүүд нэлээд гэмтсэн учир үйлдвэрийнх нь ажилчдыг авчрах хэрэгтэй болсон юм. Бараг бүх цамхагийг зассан даа.

Хоёрдугаарт, Монголын өвөл том асуудал байв. Их хүйтэн байсан учир доод тал нь хоёр

сар ажлаа зогсоосон. Гэсэн ч Австрали, Англи, Ирланд, Монголын мэргэжилтнүүд анх удаа нэг баг болж тэсгэм хүйтэнд, өдөр шөнөгүй ажиллаж, энэхүү бүтээн байгуулалтыг босголоо. Хэдийгээр бид төлөвлөсөн хугацаандаа төслөө хүлээлгэж өгөөгүй ч анхных гэдгээрээ сурсан зүйл их бий. Эхний сэнсийг босгоход 4-5 өдөр шаардсан бол сүүлийнх дээр ердөө 14 цагийг зарцуулсан. Дараа дараагийн төслүүд дээр бидний хуримтлуулсан туршлага ажлыг хөнгөвчлөх нь дамжиггүй. Өнөөдөр сэнс хэвийн эргэж буй ч жилд хоёр удаа зогсоон засвар үйлчилгээ хийж, шалгаж байх ёстой. Машины тос сольдогтой л адил. Ирэх өвлийн хүйтэнд сэнс хэрхэн эргэхээс олон зүйл мэдэгдэнэ. Бидэнд ч сурах юм их гарах болов уу.

Моран Бюте /Клин Энержи компанийн үйл ажиллагааны менежер/

Анхны салхин станцыг барихад оролцсондоо баяртай байна


-Ньюком групп салхин сэнсний бүтээн байгуулалтаар Монголдоо анхдагч боллоо. Бид харуулж чадлаа. Анхны салхин станцыг барихад гар бие оролцсондоо үнэхээр баяртай байна. "Женерал электрик" компанийн эрс тэрс уур амьсгалтай орчинд зохицсон тоног төхөөрөмжийг суулгасан учраас салхин паркийн үйл ажиллагаа ямар ч асуудалгүй гэдэгт итгэлтэй байна. Монгол инженер, ажилтнууд олон улсын зөвлөх, мэргэжилтнүүдтэй хамтран энэхүү том бүтээн байгуулалтыг босголоо. Мөн хувийн хэвшлийн

компани эрчим хүчний салбарт анх удаагаа гаднын томоохон хөрөнгө оруулалт татаж чадлаа. Энэ мэт тоочоод байвал хийсэн бас сурсан зүйл олон. Хамгийн гол нь манай компани олон улсын стандартад нийцсэн бүтээн байгуулалт хийж чадсан гэдгээрээ бахархаж байна. Дотоодынхоо ч олон компанитай хамтарч ажилласан. Багагүй зүйл мэдэж сурч авлаа. Манай компанийн хувьд Монголын ирээдүйн чиг хандлагыг нэвтрүүлсэн гэж үзэж байна.

Ц.Гансүх /"Салхит" салхин цахилгаан станцын ээлжийн инженер/ ■

ТООН МЭДЭЭ

График-1. Монгол Улсын салхины эрчим хүчний нөөц



Дэлхийн салхины эрчим хүч

График-2. Дэлхийн салхины эрчим хүчний үйлдвэрлэлийн өсөлт (ГВт)




График-3. Улс орнуудын салхины эрчим хүчний суурилагдсан хүчин чадал (ГВт)




График-4. Салхин цахилгаан станцын үйлдвэрлэлийг Оюутолгойн хэрэглээтэй харьцуулсан байдал




График-5. Дэлхийн салхины эрчим хүчний суурилагдсан хүчин чадал (жилээр)





График-6. Сэргээгдэх эрчим хүчний нөөц




Хүснэгт-1. Монгол орны салхины нөөц

Цэцэг сум	100кВт PV
Бугат сум	140кВт PV
Цээл сум	120кВт цалх,и 30кВт PV
Баянтоорой	100кВт PV
Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сум	120кВт салхи, 30кВт PV
Сэврэй, Богд сум	80кВт салхи
Манлай сум	120кВт салх 30кВт PV
Хатанбулаг	150кВт салхи
Мандах сум	80кВт салхи
Матад сум	90кВт салхи, 30кВт PV
Ургамал, Дөрвөлжин сум	150кВт PV

Хүснэгт-2. Нар салхины цахилгаан станцын

	Чадал мВт	Нөхцөл	Ашиглалтад орох хугацаа
Салхит СЦС	50	Гэрээ хийсэн	2012
Чойр СЦС	50	Гэрээ хийсэн	2015-2017
Сайншанд СЦС	50	Судалгаанышат	2015-2017
Оюутолгой СЦС	102	Гэрээ хийсэн	2013-2014
Хүрмэн СЦС	-	Судалгаанышат	2015-2017
Баянтээг НЦС	7,8	Судалгааны шат	2015-2017
Сайншанд НЦС	50	Судалгааны шат	2018-2020

График-7. Дэлхийн улс орнуудын салхины дундаж хурд



НОГООН БИЗНЕС

Б.ҮНЭНБАТ: ИЛҮҮ ХОЛЫН МӨРӨӨДӨЛ БИДЭНД БИЙ



Д.БЭХБАЯР

Ньюком группийн гүйцэтгэх захирал Б.Үнэнбаттай ярилцлаа. Тэрээр арваад жилийн өмнө Ньюком группт нягтлан бодогчоор ажилд орж байжээ. Тэр үед Салхитын салхин паркийн төслийн судалгааны ажил дөнгөж эхэлж байж. Тэгвэл тэрбээр өнөөдөр Ньюком компанийн гүйцэтгэх захирлын хувьд Салхитын салхин цахилгаан станцын нээлтийг хийж, үйл ажиллагааг нь эхлүүлж байна.

-Ньюком групп том бүтээн байгуулалтынхаа ард гарлаа. Монголчууд Ньюкомчуудаар бахархаж байна. Салхин станцаа ажиллуулаад эхэллээ. Одоо юу хийхээр төлөвлөж байна вэ?

-Юу хийх вэ гэдгээс өмнө хийсэн ажлынхаа талаар тодруулж ярьмаар байна. Салхин станцын ажлыг эхлүүлэхэд маш их цаг хугацаа, асар их хүч хөдөлмөр шаардсаныг дурдах нь зүйтэй. Хэдийгээр 2011 оноос барилгын ажил эхэлсэн боловч уг төсөлд бидний 12 жилийн нөр их хөдөлмөр шингэсэн юм. Анх 2001 онд USAID-ийн төслийн хүрээнд Монголын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн талаарх судалгаа гарсан байдаг. Уг судалгааны тайланд үндэслэн Ньюком компанийн ТУЗ-ийн дарга Ц.Болдбаатар Монгол Улсад нар, салхины эх үүсвэрийг ашиглах төсөл санаачилж, 2004 оноос судалгааны ажлуудыг эхлүүлж байлаа. Судалгаа хийхийн тулд АНУ-аас 50 метрийн өндөртэй салхины хэмжилтийн автомат станц авчирч Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Салхит ууланд суурилуулан нилээд олон жилийн турш салхины нөөцийн нарийвчилсан судалгаа хийсэн юм. Салхины хэмжилтийн үр дүн салхин парк байгуулах бүрэн боломжтойг нотолж байсан тул төсөл хэрэгжүүлэх үндсэн ажилдаа орсон билээ. 2007 онд Сэргээгдэх эрчим хүчний хууль батлагдсан нь бидэнд уг ▶

төслийг хэрэгжүүлэхэд томоохон түлхэц болсныг дурдах нь зүйтэй. Тухайн үед бид салхины нөөцөө тодорхойлчихсон, салхин станц барих бүх урьдчилсан нөхцлөө бүрэн хангасан байлаа. Мөн энэ үед Ньюком компани цахилгаан худалдах худалдан авах гэрээг Монгол Улсад анх удаа олон улсын түвшинд хүрсэн нөхцлөөр амжилтай байгуулж байсан юм. Энэ мэтчилэн олон шат дамжлага, их хөдөлмөр, итгэл сэтгэлийн дүнд станц маань бослоо. Ярихад амархан боловч тулгарах саад бэрхшээл, асуудлууд олон байлаа. Ньюкомчууд асар их тэвчээр, итгэл зүтгэл гаргаж, чармайн зүтгэсний дүнд энэ их бүтээн байгуулалтын цаана гарч чадсан бөгөөд ирээдүйд үлгэрлэх олон амжилтын эхлэлийг тавилаа.

Тиймээс төслийн судалгаанаас авахуулан өнөөдрийг хүртэл энэхүү өндөр технологийг Монголд нутагшуулах зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө оюуны өндөр түвшинд мэдлэг чадвараа дайчлан ажилласан нийт ажилтнууд, хамтрагч, түнш, гадаад, дотоодын байгууллагууддаа талархал илэрхийлье. Мөн Салхин станцын төслийн хэрэгжүүлэх том зорилт дэвшүүлээд түүнийхээ төлөө олон жилийн нөр их хүч хөдөлмөрөө зориулсан Ньюком группийн ТУЗ-ийн дарга Ц.Болдбаатар, ТУЗ-ийн гишүүд болон Ньюком группын үе үеийн захирлуудад баярласан, талархсанаа хэлэхийг хүсч байна.

Мөн Ньюком группийн хөрөнгө оруулалттай Мобиком корпорацийн нийт ажиллагсдадаа талархал дэвшүүлье. Та бүгдийн маань их хөдөлмөрийн үр шим, бүтээн байгуулалтын үр дүн зөвхөн мэдээлэл харилцааны салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулаад зогсохгүй, бидэнд эрчим хүч, иргэний нисэхийн салбарт шинэ техник технологийг нэвтрүүлэх боломж олгож байгаа юм шүү гэдгийг онцлон тэмдэглэе.

-Салхин станцыг байгуулахад асар их хөдөлмөр, тэсвэр тэвчээр гаргасан талаар та сая дурдлаа. Тэгвэл та бүхэн чухам юуны төлөө энэ их тэвчээр, хөдөлмөр гаргасан юм бол. Мөнгөний төлөө юу эсвэл арай өөр зүйлийн төлөө байв уу?

-Бидний эцсийн зорилго нэг л цэг дээр уулзана. Хувь хүний зорилго эсвэл компани, хамт олны зорилгын аль нь ч Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөө л байдаг. Бид энэ л зорилгын төлөө ажилладаг. Ирээдүй хойч үеэ сэтгэл

хангалуун, хүнд ээлтэй сайхан орчинд амьдруулахыг бид бүгдээрээ хүсдэг. Тэгвэл тэрхүү сайхан орчныг цогцлоохын тулд юу хийх вэ гэхээр дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхах хэрэгтэй. Учир нь хөгжилтэй оронд бидний хийх гээд байгаа бүх зүйл хэдийнэ бий болчихсон байдаг. Тэгэхээр тэднээс суралцах зайлшгүй шаардлагатай. Тухайлбал, сэргээгдэх эрчим хүч байгаль орчинд ээлтэйг батлаад технологийн дэвшил нь амьдралд хэрэгжээд тогтвортой ногоон хөгжлийн замыг сонгоод явж байна. Монголчууд эрчмийн салбартаа нүүрсээр дагнаж ирсэн нь нэгэн цагт Азийн цагаан дагина гэгддэг байсан Улаанбаатар хотоо хүлэмжийн хий-утгаа угаарт умбуулж агаарын бохирдлоороо дэлхийд дээгүүр ордог болгосон нь ногоон хөгжлийн зам биш байна. Агаарын бохирдол уур амьсгалын өөрчлөлтийн гол шийдэл нь сэргээгдэх эрчим хүч болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна. Бид санаачлах, эрэлхийлэх хэрэгтэй. Ньюком группын гол философи нь "Холыг ойртуулж, хоёрыг уулзуулах". Энэ философийн үндсэн тулгуур нь харилцаа холбоо, эрчим хүч, тээвэр юм. Улс орны тогтвортой хөгжлийн тулгуур, хөдөлгөгч хүч болсон эдгээр салбарт л бид идэвхтэй ажиллаж байна.

Салхин станцын нээлт бол ногоон хөгжлийн эхлэл. Энэ нь ганцхан манай компанийн амжилт биш ээ. Нийт монголчуудын амжилт. Тухайлбал, салхин станц нээлтээ хийснээр дэлхийн эрчим хүчний газрын зурагт ганцаараа шахуу хараар тэмдэглэгддэг байсан Монгол Улс ногоон өнгөөр тэмдэглэгдэх хэмжээний түүхэн үйл явдал гэж ойлгох нь зөв болов уу. Монголчууд хар хүрэн өнгөтэй, байнга нүүрс түлдэг улс биш. Ногоон хөгжилд хөл тавьж буй асар их сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй улс гэдгийг баталж буйн жишээ нь Салхитын станц. Онгон байгальтай, нүүдэлчин улс салхины эрчим хүчний нөөцөө ашиглаж, цахилгаан эрчим хүч гарган төвийн бүсийн системд нийлүүлж ногоон хөгжил рүү том алхам хийж эхэллээ гэдэг ойлголтыг олон улсад өгч байгаа нь чухал юм.

Мөн цаашид сэргээгдэх эрчим хүчний салбарт хүч үзэх хувийн хэвшлийнхэнд итгэл найдварыг төрүүлж буйгаараа ихээхэн ач холбогдолтой. Учир нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа эрчим хүчний салбарт амжилттай

хэрэгжиж болдгийн баталгаа болж байгаа юм. Энэ утгаараа бид Монгол Улсдаа нэр хүнд бүхий бизнесийн хамтрагч болж байна. Тухайлбал, манай компанитай хамтрах саналыг олон улсын нэр хүндтэй компаниуд тавьж эхлээд байна. Японы "Softbank" манай компанитай хамтраад бид Өмнөговь аймгийн нар, салхины нөөцийг ашиглан дараагийн сэргээгдэх эрчим хүчний паркыг барих ажилдаа орсныг хэлмээр байна. Энэ удаа бид их туршлага хуримтлуулсан болохоор Салхитын цахилгаан станцаас зургаа дахин хүчин илүү хүчин чадалтай салхин парк барьж байгуулах зорилт тавин ажиллаж байна. Үүнээс илүү холын мөрөөдөл бидэнд бий. Монгол орны сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглаж, Азийн орнууд руу цэвэр эрчим хүч экспортлох зорилготой олон улсын Азийн эрчмийн супер сүлжээ төсөлд оролцох хэтийн зорилготойгоор тэмүүлж байна.

-Салхин станц нээлтээ хийснээс хойш эрчим хүч үйлдвэрлэж байгаа юу?

-Төвийн эрчим хүчний системд цахилгаанаа амжилттай нийлүүлж байна. Төслийг улсын комисс эхний хэсгийг хүлээж авсан бөгөөд өдөр тутам цахилгаан эрчим хүчний тоолуур ажиллаж байгаа.

-Цахилгаан нийлүүлэхэд төлбөрийн асуудлыг хэрхэн зохицуулахаар байгаа вэ?

-Сэргээгдэх эрчим хүчний хуулинд нэг кВтцаг цахилгааныг 8-9.5 центээр худалдах, худалдан авахаар заасан. Манай нийт ниилүүлж байгаа эрчим хүчний хэмжээ нь Монгол Улсын жилийн цахилгааны үйлдвэрлэлийн таван хувиас хэтрэхгүй учраас хэрэглэгчдэд шууд нөлөөлөх үнийн дарамт тун бага юм. Нөгөө талаас энэхүү төслийн гол давуу тал нь ирээдүйд нүүрсний станцаас нийлүүлэх эрчим хүчний үнэ өсөж байхад салхины эх үүсвэрээс үйлдвэрлэсэн эрчим хүчний үнэ тогтвортой байх явдал. Мөн энэ төсөлд Мянганы сорилтын сангаас дэмжлэг үзүүлж байсан. Тухайлбал, Салхитын салхин цахилгаан станцыг төвийн эрчим хүчний системд холбоход шаардлагатай дэд бүтцийн өргөтгөлийн ажлуудыг хийж өгсөн байдаг.

-Салхитын станц хичнээн ажлын байр бий болгож байгаа бол?

-Станцыг барьж байгуулах оргил ачааллын үед 500 орчим хүн ажиллаж

► байсны 94 хувь нь монголчууд байлаа. Цаашдаа тус станцад 25-30 орчим хүн ажиллана. Орчин үеийн техник технологийн давуу тал хүний хөдөлмөрийг хөнгөвчилдөг, олон хүн ажиллах шаардлага байдаггүй шүү дээ. Мөн бүрэн автоматжсан ажиллагаатай дэд станцыг барьсан учраас станцд хүний оролцоо бага байх юм.

-Ньюком групп сэргээгдэх эрчим хүчнээс өөр ямар салбарт бизнесийн хүрээгээ өргөтгөхөөр төлөвлөж байна вэ?

-Манай компани иргэний агаарын салбарыг ногоон технологид ойртуулахыг эрмэлзэж байна. Аль болох шинэ, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд анхаарч байгаа. Тухайлбал, өнгөрсөн оноос үйл ажиллагаандаа Канад улсын сүүлийн үеийн технологид суурилсан Q400 маркийн агаарын хөлөг ашиглаж байна. Мөн боловсролын салбарт шинэчлэл авчрах үүднээс АНУ, Монголын хамтарсан их сургууль байгуулахаар төсөл хэрэгжүүлж байгаа. Ингэснээр Монголдоо Америкийн түвшний мэргэжилтэн бэлтгэх бүрэн бололцоотой болох юм.

Бидний гол зорилго Монгол Улсад зайлшгүй шаардлагатай, өндөр мэдлэгт тулгуурласан, нарийн технологи шаардсан салбарт бизнес эрхлэх явдал юм. Жишээлбэл, ашигт малтмал олборлож эцсийн бүтээгдэхүүн бий болгоход шаардлагатай байгальд ээлтэй, өндөр технологи нэвтрүүлэх зорилго бүхий компани байгуулан ажиллаж байна.

Хувь хүнийхээ хувьд өнөөдөр

Улаанбаатар хотод давхар зам баригдаасай гэж боддог. Хүнд хамгийн чухал зүйл мөнгөнөөс илүү цаг хугацаа байдаг. Манай ард түмэн цаг бол алт хэмээн айлдсан шүү дээ. Бизнес ч ялгаагүй. Гэртээ 10-20 минутад харьдаг бол ямар сайхан байх вэ. Хэрвээ нийтийн тээврийн хангамж, дэд бүтэц сайн бол хүмүүс хувийнхаа машинаар бүтэн цагаар түгжрэл үүсгээд явахын оронд автобусаар, метрогоор түргэн очдог бол ямар сайхан байх вэ. Бид, бидний үр хүүхэд заавал агаарын бохирдол ихтэй хотод амьдрах ёстой биш юм аа. Байгалийн сайхан, цэвэр орчинд амьдарч яагаад болохгүй гэж. Үүний тулд хол замыг хялбархан, хурдан туулдаг болох нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай юм.

-ТЭЦ V-ын төсөл ямар шатанд явж байна вэ?

-Одоогоор тендерийн сонгон шалгаруулалт дууссан. Эрчим хүчний дутагдалд орсон өнөө үед уг төслийн ажил хэрэгжих нь зайлшгүй. Төслийн үйл ажиллагаанд өөрсдөөс хамаарах бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

-Төрийн бодлого бизнесийн салбарыг дэмжиж, хаалгаа нээж чадаж байна уу. Тэр тусмаа алсыг харсан төсөл хэрэгжүүлэхэд төрийн оролцоотой холбоотой ямар хүндрэл бэрхшээл гарч байна вэ?

-Хувийн хэвшил өөрийн хөрөнгөө гаргаад бизнес хийж байхад төрийн оролцоо гэхээсээ илүү хууль эрх зүйн орчныг нь л бүрдүүлээд өгөх хэрэгтэй. Түүнээс чи ингэх ёстой, тэгэх хэрэгтэй гээд үйл ажиллагаанд нь хэт оролцох

хэрэггүй. Харин энэ хүрээнд ажиллах ёстой гэсэн зааг, орчныг нь тодорхой болгох нь чухал. Нөгөө талаасаа төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчмаа улам боловсронгуй болгож ажиллах хэрэгтэй. Шинэ Зеландад ихэнх бизнес нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны зарчмын дагуу явдаг. Би тус улсад сурч байсан болохоор багагүй судалсан л даа, энэ талаар. Үүний гол давуу тал нь хоёр талын хяналт бий болж байгаа юм. Төр, хувийн хэвшил хоёр хамтдаа зүтгэж бие биенээ, ойлгож байж улс орны тогтвортой хөгжил урагшилна. Үүнээс гадна манай хөрөнгийн биржийн хөгжил сул байгаа нь хөгжлийн хөдөлгүүрийг удаашруулаад байна. Хөрөнгийн бирж аль болох хурднаар олон улсын түвшинд хүрч байж хөгжил бас хурдтай урагшилна гэж боддог.

-Манай томоохон компаниуд эхнээсээ public буюу олон нийтийн болоод эхэлсэн. Тэгвэл танай компанийн хувьд ямар төлөвлөгөөтэй байгааг сонирхмоор байна.

-Ньюком группэд энэ талын туршлага бол бий. Олон нийтийн гэдэг ойлголтыг би хувьдаа хөрөнгийн биржтэй шууд холбоотой гэж үздэг. IPO хийх үү. Хэзээ хийх вэ. Дотоодын зах зээлийг сонгох уу эсвэл гаднын зах зээлд гарах уу. Иргэдийн санхүүгийн боловсролоос бас хамаарна. Манай компанийн хувьд аль нэг салбарын компаниа олон нийтийн болгох алсын зорилго бий. Гэхдээ цаг хугацаа нь арай болоогүй байна. ■

СЭРГЭЭГДЭХ ДЭЛХИЙ

ЭРЧИМ ХҮЧНИЙ “ГАЛАВ ЮҮЛЭХ” ЦАГААР

Б.ЦЭЦЭН

Олон улс тэр дундаа хөгжиж буй орнуудын эрчим хүчний

салбарт ойрын жилүүдэд эргэлт гарч, байгалийн сэргэх чадвараар эрчим хүчний салбараа “цэнэглэж”

байна. Өнгөрсөн жил сэргээгдэх эрчим хүчний салбарт дэлхий нийт 244 тэрбум ам.долларын хөрөнгө ►►



оруулалт хийжээ. Тус салбарын хүчин чадал нэмэгдэх тусам нарнаас гаргаж авах эрчим хүчний үнэ 30-40 хувь буурч буйг харуулж байгаа. 2007 оноос хойших сэргээгдэх эрчим хүчний салбарын өсөлтийг задалбал хөгжингүй орнууд хөгжиж буй улсуудаас даруй 2.5 дахин их хөрөнгө зарцуулжээ. "Bloomberg New Energy Finance" -ын захирал Майкл Либрих "Сэргээгдэх эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт гурав дахь жилдээ 200 сая ам.доллараас даван, хөгжиж буй орнууд хүч түрж, үнийн өрсөлдөх чадвар сайжирч байна. Гэвч нүүрсхүчлийн хорт хаягдал өсөх хандлагатай байна. Өнгөрсөн онд хатуу түлшний салбарт нийт 15 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт урсан орсон байна" хэмээжээ.

Сэргээгдэх эрчим хүчний дэлхий нийтийн чадал өнгөрсөн онд өмнөх оныхоос найман хувиар нэмэгдэж 1.470 гегават болсон бөгөөд үүн дотроо салхи 39 хувиар хамгийн өндөр байгаа бол ус, нар араас нь орж буй. Гэсэн ч Монгол Улсад зохион байгуулсан Ногоон хөгжлийн үндэсний чуулган дээр танилцуулсан хоёр томоохон тайланд сэргээгдэх эрчим хүчний салбарын гол асуудлыг хөгжингүй орнууд дахь тус салбарыг чиглэсэн бодлогын тогтворгүй байдал, үүнээс үүдсэн хөрөнгө оруулалтын бууралт гэдгийг онцолсон байна. Учир нь өнгөрсөн жил АНУ болон Европын зах зээл дээр нарны эрчим хүчний үнэ суларснаас үүдэн дэлхий нийтийн энэ салбар дахь хөрөнгө оруулалт өмнөх жилээс 12 хувиар буурчээ.

Сэргээгдэх эрчим хүчний бодлого

барин ажиллаж буй нийт 138 орны гуравны хоёр нь "хөгжиж буй" гэсэн тодотголтой. Тэргүүнд нь манай урд хөрш цойлж явна. Өнгөрсөн онд тус улс сэргээгдэх эрчим хүчний салбарын "од тоглогчийн" байр сууриа тодотгож нийт хөрөнгө оруулалтаа 22 хувиар нэмэгдүүлж 67 тэрбум ам.доллар болгожээ. Их өсөлтөө байгаль орчин хэмээх өндөр үнээр олж авсан гэгддэг Хятад улс хүч түрэн орж ирж буй нь шавхагдаж буй баялаг, байгальтай нь холбоотой гэж мэргэжилтнүүд үздэг. Нарны эрчим хүчний төслүүдэд нэлээд хүч хөрөнгө хаяж эхэлсэн нь дээрх өсөлтийг ч хөшүүргэджээ. Сэргээгдэх эрчим хүчний салбарт огцом тодорч буй бусад тоглогчид Өмнөд Африк, Морокко, Мексик, Чили, Кени багтаж байна. Мөн Ойрхи Дорнод, Африк тив өнгөрсөн жил хөрөнгө оруулалтаа 228 хувиар өсгөж 12 тэрбум ам.доллар болгосон нь бүсийн хэмжээнд тэргүүлэх үзүүлэлт аж.

Харин Сэргээгдэх эрчим хүчний зах зээлийн 2011 оны аварга АНУ хөрөнгө оруулалтаа эсрэгээр нь 34 хувиар бууруулж, 36 тэрбум ам.доллар болгожээ. Үүнийг зах зээлийн мэргэжилтнүүд АНУ-ын улс төрийн бодлогын тодорхойгүй байдалтай холбон тайлбарлаж байна. Хөрөнгө оруулалт бууралттай орнуудад Итали, Испани мөн оржээ. Харин Герман улс өнгөрсөн онд нарны эрчим хүчний чадлаа 7.6 гегаваттаар нэмсэн нь дэлхийд шинээр нэмэгдсэн нийт сэргээгдэх эрчим хүчний 27 хувь аж. Гэсэн ч улсын хэмжээнд нийт сэргээгдэх эрчим хүчний салбар дахь

хөрөнгө оруулалт 35 хувиар буурч 20 тэрбум ам.доллар болжээ. Энэ нь нарны эрчим хүчний үнэ буурч, салхины эрчим хүчний салбар дахь хөрөнгө оруулалт багасч байгаатай холбоотой юм.

Хөгжингүй орнуудаас ирж буй сайн мэдээллийн нэг нь Японы хүчтэй бодлого юм. Тус улсын сэргээгдэх эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт өнгөрсөн жил 73 хувиар нэмэгдэж, 16 тэрбум болжээ. Тус улсын Засгийн газраас уг салбар дахь бүтээн байгуулалтыг дэмжиж, үнэ тариф дээр татаас олгохоор болсон нь салхины эрчим хүчний жижиг төслүүд олноор хэрэгжихэд нөлөөлжээ. Нэгдсэн үндэстний байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн гүйцэтгэх захирал Артурос Зервос "2012 он бол сэргээгдэх эрчим хүчний хувьд бас нэгэн тэмдэглэлт он байлаа. Дэлхийн 138 орон тус салбарыг тусгайлан авч үзсэн бодлого зохицуулалттай болсон байна. Энэ нь улс төрийн хүсэл зориг хамгийн их хэрэгтэйг харуулж байна" хэмээжээ.

Хэдийгээр 2012 онд дэлхийн хэмжээнд бодлогын дэмжлэг буурсан ч орон нутгийн засаг захиргааны зүгээс эрх мэдлийнхээ хүрээнд зохицуулалт хийж, төслүүдийн санхүүжилтийг хялбарчлах, мэдээллээр хангах, сурталчлах зэрэг зүтгэл ихээхэн дээшилсэн байна. Дэлхийн дулаарлыг сааруулах, CO₂-ыг 20 хүртэлх хувиар багасгах зорилготой эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөрт Европын холбооны 1116 хот, суурин газрын дарга нар шинээр нэгдэж, өнгөрсөн жил гарын үсгээ зуржээ. Мөн энэ салбарт ажиллах иргэдийн тоо ч сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж буйг мэргэжилтнүүд сайшааж байна. Өнгөрсөн жилийн байдлаар сэргээгдэх эрчим хүчний салбарт шууд ба шууд бусаар нийт 5.7 сая хүн ажилласныг тогтоожээ.

Дэлхий ертөнц өнөөдөр шавхагдах хатуу баялгийнхаа үүцийг хаах цаг ойртож байгаа нь олон улсыг сэргээгдэх баялагт хошуурахад хүргэж буй. Энэ нь ч сэргээгдэх эрчим хүчний "галав юүлж" буйг харуулж байна. ■



650 тонны өөрөө явдаг краныг БНХАУ-аас хэсэгчилэн тээвэрлэж буй нь



Салхин цахилгаан үүсгүүрийн суурийн цутгалт



"Салхит" салхин цахилгаан станцын ээлжийн инженерийн хамт олон





Хамгийн сүүлийн салхин сэнсийг угсарч дууссаны дараа барилга угсралтын ажил гүйцэтгэгч Лейтон ХХК-ын ажилчид



Бүтээн байгуулалтын ажил эхэлж байгаа нь



Баруун гар талаас Эрчим хүчний сайд М.Сономпил, Ньюком группын ТУЗ-ын гишүүн Р.Ареинцогт, "Клин Энержи" компанийн гүйцэтгэх захирал С.Энх-Амгалан нар салхин станцын нээлтийн үеэр.



Шэйне Фицсимонс /Женерал Электрик компанийн Санхүү хариуцсан захирал/



БОНХ-ийн сайд С.Оюун Салхитын салхин станцын нээлтийн үеэр.

ШИЙДЭЛ

ТОГТВОРТОЙ СТРАТЕГИ

Орчуулсан Р.ГАНТУЛГА

Өнөө үед ихэнх компани нүүрсхүчлийнхийн ялгаруулалтыг бууруулах, хог хаягдлыг багасгах, үйл ажиллагааныхаа үр ашгийг дээшлүүлэх зэргээр ногоон чиг рүү явж байгаа нь тодорхой. Гэхдээ энэ нь тогтвортой стратеги байж чадах болов уу?

Компаниуд тогтвортой стратегитай болохын тулд хувь нийлүүлэгчдийнхээ ашгийг нэмэгдүүлж, байгаль орчин, нийгэм болон засаглал (БОНЗ)-ын хэмжүүрээр компанийн гүйцэтгэлээ сайжруулж, оролцогч талуудын ашиг сонирхлыг шийдвэрлэх ёстой. Одоогийн байдлаар санхүүгийн гүйцэтгэл болон БОНЗ-ын гүйцэтгэл нь хуваагдмал байдалтай оршин буй нь удаан хугацаанд гарах үр дүнг сулруулдаг байна. Үүнтэй холбоотойгоор компаниудын дагаж мөрдвөл зохих хоёр шаардлага гарч ирдэг. Нэг нь БОНЗ-ын нэн тэргүүний шийдвэрлэвэл зохих чухал асуудлуудад анхаарах, нөгөө нь эдгээр асуудлыг ач холбогдлоор нь эрэмбэлсэн үндсэн инноваци хийх. Энэ хоёр шаардлагыг үл тоомсорлох нь нөхцөл байдлыг хүндрүүлэх эрсдэлтэй. Нөгөө талаас олон компани удаан хугацаанд тогтвортой хөгжих зорилгоо тодорхойлж чадахгүй байна. Нийгэмд эерэгээр нөлөөлөх үйл ажиллагаанууд ямар ч компанийг зардал гаргахад хүргэдэг. Харин тухайн компани зардал гаргахгүй байх нь ашигтай боловч нийгэмд хор хөнөөлтэй байдаг.

Тогтвортой стратегийг хөгжүүлдэг инновацийн стратегиудыг бий болгож, ашиглахын тулд зайлшгүй шаардагдах дөрвөн санаачилга бий. Компаниуд оролцогч талуудынхаа ашиг

сонирхлын асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ гүйцэтгэлээ сайжруулах боломжийн үндсэн ойлголтуудыг энэхүү нийтлэлээр дамжуулан хүргэж байна.

1. БОНЗ-ЫН АСУУДЛЫГ АЧ ХОЛБОГДЛООР НЬ ТОДОРХОЙЛОХ

Мэдээж БОНЗ-ын хүрээнд шийдвэрлэх асуудлуудын жагсаалтыг гаргавал хэзээ ч дуусахгүй мэт

байдлаар АНУ-ын Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын удирдлага (Sustainability Accounting Standards Board – SASB) нь БОНЗ-ын тулгамдсан асуудлуудыг ангилж, тодорхойлох төслийн цогц ажлыг боловсруулж байна. Энэ төслийн хүрээнд арван салбарын 88 үйлдвэрийг хамруулан БОНЗ-ын тулгамдсан асуудлуудыг ач холбогдлоор нь эрэмбэлсэн



санагдана. Компаниудад шийдвэрлэх шаардлагатай олон асуудал байдаг ч асуудал тус бүрийг хялбархан шийдвэрлэх боломжгүй. Тухайн асуудлын ач холбогдлоос үл хамааран хувь нийлүүлэгчид хэр ашиг олох нь тухайн компанийн үйл ажиллагаа явуулдаг салбар болон компанийн стратегиас хамаардаг. Одоогийн

хүснэгт (Materiality Map) гаргажээ. Хүснэгтэд 0.5-аас тав хүртэлх оноогоор үнэлгээ өгөх бөгөөд таван оноо нь шийдвэрлэвэл зохих хамгийн чухал асуудлыг харуулдаг. Энэхүү стандарт нь компаниудад тулгарч буй асуудлуудыг ач холбогдлоор нь үр дүнтэй байдлаар тодорхойлохын тулд олон мянган эх сурвалжийг ▶

► хуулбарлах хэлбэрээр явагддаг байна.

2. САНХҮҮГИЙН БОЛОН БОНЗ-ЫН ГҮЙЦЭТГЭЛ ХООРОНДЫН ХАРИЛЦААГ ТОО ХЭМЖЭЭГЭЭР ТОДОРХОЙЛОХ

Аливаа компани БОНЗ-тай холбоотой асуудлаа ойлгосон цагт л санхүүгийн гүйцэтгэлд хэр зэрэг ахиц, дэвшил гарч, энэ нь хэрхэн нөлөөлж буйг үнэлж чадна. Гэвч санхүү болон БОНЗ-ын гүйцэтгэлийн хоорондох харилцааг үнэлэхэд олон хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд энэ нь үйл явцыг улам төвөгтэй болгодог. БОНЗ-ын гүйцэтгэлийг нарийвчлан үнэлэх боломж хараахан бүрэлдээгүй байгаа SASB уг асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Энэ бэрхшээлээс үл хамааран БОНЗ-ын гүйцэтгэлд гарч буй ахиц, дэвшил бүр нь санхүүгийн үр дүнд эерэг болон сөргөөр нөлөөлж байгаа эсэхийг тодорхойлж гаргаснаар компаниуд өөрийн гэсэн үнэлгээтэй болно.

3. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛ ЯВЦ, БИЗНЕСИЙН ЗАГВАРУУД ГАРГАХ

Тухайн компани БОНЗ-ын ямар асуудлыг шийдвэрлэх нь нэгэнт тодорхой болсон тохиолдолд өрсөлдөгч компаниудаа асуудал тус бүрээр хэрхэн харьцуулахаа тодорхойлох зорилт тавих хэрэгтэй. Ингэснээр компаниуд өөрсдийн гүйцэтгэлийн түвшин чухам хаана байгааг олж мэдэхээс гадна хэрэв гүйцэтгэл нь салбарын жишгээс доогуур үзүүлэлттэй байгаа бол түүнийг сайжруулах боломжтой юм. Энэ нь урт хугацааны туршид компанийн үр ашгийг дээшлүүлж, санхүүгийн гүйцэтгэлийг сайжруулахад ихээхэн ашиг тустай. Санхүүгийн гүйцэтгэл болон БОНЗ-ын гүйцэтгэлийн аль нэгийг зайлшгүй сонгох шаардлага (trade-off) гарсан тохиолдолд тухайн компани эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд байгууллагаа бүхэлд нь хамарсан инноваци хийх шаардлагатай. Үүнд шинэ бүтээгдэхүүн, бизнесийн загварууд байнга шаардагдах болно. Эдгээр өөрчлөлтийг хийснээр тухайн компани өөрт тохиолдох эрсдэлийг хөнгөвчлөх боломжтой юм.

4. КОМПАНИЙН ИННОВАЦИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ОЙЛГУУЛАХ

Энэхүү үйл явцын чухал хэсэг бол бусадтай харилцах, мэдээллээр хангах. Үр дүнтэй харилцаагүйгээр ямар ч компани тухайн инновацийн явцад санхүү болон БОНЗ-ын гүйцэтгэл хэрхэн сайжрах талаар зөв ойлголтыг хувь нийлүүлэгч, оролцогч талуудад ойлгуулах боломжгүй. Хувь нийлүүлэгчдийнхээ итгэлийг олж авахын тулд тухайн хөрөнгө оруулалтыг зөвтгөх чухал мэдээллээр тэднийг хангах нь аль ч компанийн хувьд туйлын чухал ач холбогдолтой. Иймээс компаниуд сүүлийн үед нэгдсэн тайлан гаргах болсон нь хүчээ авч байна. Нэгдсэн тайлан нь аль нэгийг нь зайлшгүй сонгох хүндхэн шаардлага (trade-off)-ыг тодорхойлох, мөн тухайн компанийн үйл ажиллагаа хэрхэн явж буйг илэрхийлсэн санал, хүсэлтийг сайжруулах аргачлал юм. Үүний дүнд компаниуд үйл ажиллагаагаа сайжруулах асуудлыг дэмжих боломжтой. Нэгдсэн тайлан гаргаснаар удирдлага болон ажилтнууд өөрсдийн шийдвэртээ санхүүгийн болон БОНЗ-ын нөлөөллийг бодолцдог болгох, улмаар сахилга батыг улам сайжруулна. Сахилга батын энэхүү байр суурь нь цаашид бүр ч их инноваци хийх түлхэц болж өгдөг байна.

Өөрчлөлт хийхэд тулгарах бэрхшээл

Тогтвортой стратегийг хөгжүүлэх үйл явц үргэлж ил тод байх нь үгүй. Өөрчлөлт хийх үед тулгардаг бөгөөд зайлшгүй давж гарах шаардлагатай дөрвөн төрлийн саад, бэрхшээлийг олж тогтоосон байдаг. Үүнд:

1. Богино хугацааны шагнал, урамшуулал: Тогтвортой байдлын асуудлыг шийдвэрлэхэд урт хугацаа шаарддаг тул богино хугацааны гүйцэтгэлд тохирсон шагнал, урамшууллыг ажилтан, албан хаагчдад олгож байх нь чухал. Энэ нь гүйцэтгэлийн түвшин ямар нэг байдлаар буурахаас урьдчилан сэргийлж буй хэрэг. Гэвч энэ төрлийн шагнал, урамшууллын сул тал нь БОНЗ-ыг сайжруулах биш харин ч муутгаж,

инноваци хийхэд шаардлагатай хамтын ажиллагааг ажилтнуудын дунд зөв хуваарилахад саад учруулдаг байна.

2. Экспертиз дутагдах:

Шинэ стратеги шинэ ур чадвар байнга шаардагддаг. Шинэ ур чадваргүйгээр байгаль орчин болоод нийгмийн сорилт, бэрхшээлийг үр дүнтэй шийдвэрлэх боломжгүй. Үүний уршгаар урт хугацааны зорилтод хүрэхгүй байх эрсдэлтэй.

3. Хөрөнгө төсөвлөх

хязгаарлалт: Энэ тал дээр авч үзэх хоёр чухал зүйл бий. Нэгдүгээрт, тухайн төсөлд эзэлж буй байгаль орчин болон нийгмийн үнэ цэнэ. Хоёрдугаарт, энэ нь тухайн компанийн нэр хүндэд ямар нөлөөтэй болох. Өөрсдийн үнэлгээний арга барил, хөрөнгө төсөвлөх үйл явц зэрэгт санхүүгийн бус хэмжүүр, үзүүлэлтийг тохиромжтой байдлаар тусган нэгтгэх системчилсэн арга барилаа олсон компаниудын хувьд давуу талтай юм. Ингэснээр компаниуд өөрсдийн зорилгодоо хүрэхэд салшгүй хэсэг болох БОНЗ болон санхүүгийн гүйцэтгэлүүдийн хоорондох харилцааг сайтар ойлгох боломжтой болно.

4. Хөрөнгө оруулагчдын

дарамт: Алсын хараатай хөрөнгө оруулагчдыг татах нь тогтвортой стратеги хөгжүүлэхээр зорьж буй компаниудын хувьд зайлшгүй хийх ёстой зүйл юм. Аливаа компани харилцаа холбоо болон нэгдсэн тайланд анхаарлаа хандуулснаар урт хугацааны хөрөнгө оруулагчдын тоогоо нэмэх боломжтой.

Компаниудын тоо нэмэгдэх тусам тогтвортой стратегийг хөгжүүлэх нь туйлын чухал болж байна. Дарамт, шахалт байгаа нь тодорхой. Компаниудад урт хугацааны зорилгодоо хүрэхэд дэмжлэг болох хэрэгслүүд олон туршилтын явцад хувьсан өөрчлөгдсөөр ирсэн. Гэвч үүнээс үл шалтгаалан гараагаа сайн эхлэх нь чухал юм. Тогтвортой стратегийг бий болгосноор компаниуд өнөө үеийнхний хэрэгцээ, шаардлагад нийцсэн тогтвортой нийгмийн шинэ үеийг бий болгож чадна.

Эх сурвалж: Harvard Business Review сэтгүүл ■

ТАТВАР

НӨАТ БА ТҮҮНИЙ ШИНЭЧЛЭЛ

Б.АЛТАЙ

“Төрийн дор татвар оршиж, татварын дор төр оршдог” гэсэн үг бий. Татвар бол иргэн болон аж ахуйн нэгж төрөө санхүүжүүлж буй нэг хэлбэр гэж ойлгож болох юм. Гэвч татварын талаарх бидний ойлголт өнөөдөр харилцан адилгүй. Тиймээс манай сэтгүүл энэ удаагийн дугаартаа Нэмэгдсэн өртгийн албан татвар / НӨАТ/-ыг онцолж байна. НӨАТ нь шууд бус буюу хэрэглээний татварын нэг төрөл. Монгол Улсад мөрдөж буй Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Онцгой албан татвар, Автобензин дизелийн түлшний албан татвар нь хэрэглээний татварын гол төлөөлөл аж. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь өөрийн худалдан авсан эд бараа, түүхий эд, материал, үйлчилгээндээ тодорхой хэмжээний нэмүү өртөг шингээж шинэ бараа, үйлчилгээ бий болгох буюу шинэ хэлбэрт оруулан борлуулдаг.

Энэхүү нэмэгдсэн өртөг буюу үнэлэмжид ногдуулдаг татварыг НӨАТ гэж нэрлээд цөөнгүй жилийг үджээ. Уг татварын харилцаа нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг татвар дамжуулагч байгууллага болгон хувиргадаг. Тиймээс эчнээ танил болсон НӨАТ-ын талаарх илүү мэдлэг, мэдээлэл хэрэгтэй болов уу.

НӨАТ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүх шат дамжлагаар тооцогдож, өмнөх шат дамжлагын НӨАТ-ын хасалтыг хийж, эцсийн бүтээгдэхүүний үнэ дээр нэмэгдэж, улмаар хэрэглэгчийн хүлээж авсан



бараа, ажил, үйлчилгээнд ногддог татвар юм. Иймд НӨАТ нь бизнесийн үйл ажиллагаанд ногдуулдаг бус бизнесийн үйл ажиллагаагаар дамжин хураагддаг хэрэглээний татвар гэж ойлгож болох нь. Түүнчлэн төсвийн тогтвортой эх үүсвэр болохоос гадна татварын тогтолцоог боловсронгуй болгоход ихээхэн ач холбогдолтой. Мөн эцсийн дүндээ аливаа улс орны хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагуудыг үнэн зөв санхүүгийн тайлан мэдээлэл бэлтгэдэг болгох, татварын хөндлөнгийн мэдээллийг цуглуулах найдвартай хэрэгсэл аж. Үүнээс гадна эх үүсвэр болох, ингэснээр далд эдийн

засаг буюу хар зах зээлийг багасгах, улмаар арилгах, мөнгөний урсгалыг төр өөрийн хяналтад байлгаж, хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагыг санхүүгийн цэгцтэй тогтолцоонд оруулах эерэг талтай.

Дахин сануулахад

Монгол Улс Худалдааны албан татварыг НӨАТ-аар солих асуудлыг 1996 оноос эхлэн судалсан байдаг. 1997 онд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр боловсруулсан НӨАТ-ын тухай хуулийн төсөл 1998 оны нэгдүгээр сард УИХ-аар баталж мөн оны долоодугаар

сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлжээ. Монгол Улс Худалдааны албан татварыг НӨАТ-аар солих бэлтгэл ажлыг нэг жилийн турш нарийвчилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нэвтрүүлсэн аж.

Мөн НӨАТ-ын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс 58 хоногийн дараа буюу 1998 оны наймдугаар сарын 28-ны өдөр анхны нэмэлт өөрчлөлт оруулж, тухайн өөрчлөлтөөр хувь хэмжээг 13 хувь болгон өсгөж, олон тооны чөлөөлөлтийг хүчингүй болгосон байна. Тэдгээр өөрчлөлтийг гурван хоногийн дараагаас мөрдөхөөр хуульчилж байсан түүх бий. Үүнээс хойш хувь хэмжээг 2000 оны арваннэгдүгээр сарын 17-ны өдрийн хуулиар 15 хувь, 2006 оны зургаадугаар сарын 29-ний өдрийн хуулийн шинэчилсэн найруулгаар 10 хувь болгон өөрчилж байснаас гадна татвар төлөгчөөр бүртгэх босгыг 2001 оны зургаадугаар сарын 29-ний өдрийн хуулиар 15 сая төгрөг байсныг 10 сая төгрөг болон бууруулж байжээ. Хуулиудад оруулсан ихэнх нэмэлт өөрчлөлт нь тодорхой салбаруудыг татвараар дэмжихэд чиглэсэн чөлөөлөлттэй холбоотой байсан гэдэг.

Монгол Улсад нэвтрүүлсэн татваруудаас НӨАТ нь ОУВС, Дэлхийн банк, АХБ, БНСУ-ын KOICA, АНУ-ын USAID, Япон улсын JICA зэрэг байгууллагаас “олон улсын стандарт түвшинг хангасан бүтэцтэй, хэрэгжилтийн түвшин нь хангалттай сайн” гэсэн үнэлгээ авчээ. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуульд зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа импортлох, экспортлох эгтгээд, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татварыг эцсийн хэрэглээнд ногдуулан хураан авч улсын төсөвт төлдөг.

Манай улсын хувьд өнөөгийн байдлаар борлуулалтын орлогын хэмжээ нь 10 сая төгрөг ба түүнээс дээш борлуулалтын орлоготой хуулийн этгээд НӨАТ төлөгчөөр бүртгүүлж байна. Энэ босгоос доогуур орлоготой хуулийн этгээдүүд НӨАТ төлөгчөөр бүртгэгдэхгүй ч борлуулалтын орлого нь найман сая төгрөг хүрсэн, эсхүл Монгол Улсад хоёр сая ам.доллар ба түүнээс дээш хөрөнгө оруулалт хийсэн

хуулийн этгээд НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх боломжтой. Эдгээрээс бусад болон банк, санхүүгийн байгууллагууд, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ эрхлэгч гэх мэтээр нэлээд олон салбар дахь аж ахуйн нэгж, байгууллага энэ татвараас чөлөөлөгдөж байгааг салбарынхан учирлах аж.

НӨАТ-ын босго, хувь хэмжээ

Татвар төлөгчөөр буюу татвар ногдуулан хураан авч төсөвт төвлөрүүлэхээр бүртгүүлэх босгыг оновчтой тогтоох нь НӨАТ-ын системийн хамгийн чухал асуудал болжээ. Босгыг хэт өндөр тогтоох нь татвар төлөгчдийн тоо, татварын бааз, суурийг эрс бууруулж, татвараас гадуур борлогдох бараа ажил үйлчилгээний хэмжээ ихсэх ч нөгөө талаас аж ахуйн нэгжүүдэд учрах татварын дарамтыг багасгах сайн талтай гэх. Нөгөөтэйгүүр босгыг оновчгүй тогтоосноор НӨАТ-ын систем гажуудаж, татвар төлөгчдийн дунд тэгш бус байдал үүсгэх ба татвар хураалт, хяналтын өндөр зардал шаарддаг аж.

Онолын хувьд татвар хураалт, ногдуулалтын зардлыг эс тооцвол НӨАТ-ын хамгийн тохиромжтой босго нь “тэг” юм. Босгогүй байснаар татвар төлөгчдын дунд тэгш байдал бий болж чөлөөтэй өрсөлдөх боломжтой болохоос гадна татварын орлого ч өсдөг аж. Гэвч ОУВС-ын судалгаагаар НӨАТ-тай орнуудын татвар төлөгчдийн хамгийн өндөр борлуулалтын орлоготой 10 хувь нь нийт НӨАТ-ын орлогын 90 хувийг бүрдүүлдэг тухай тооцоо гарсан байна. Үүнээс үзэхэд НӨАТ-т бүх нийтээр хамруулах гэж оролдох нь хэт бага орлоготой хэсгээс мөн багахан хэмжээний татварын орлого хураахын тулд өндөр зардал гаргахад хүргэж болзошгүйг Сангийн яамын дэд сайд С.Пүрэв хэллээ. Сүүлийн 10 жилийн статистик мэдээнээс үзэхэд НӨАТ-аар төсвийн нийт татварын орлогын 17-33 хувийг буюу нийт төсвийн орлогын 14-22 хувийг эзэлж байгаа нь НӨАТ-ын ойролцоо хувь хэмжээтэй бусад улс орнуудын түвшингээс харьцангуй дээгүүр үзүүлэлт болохыг тэрбээр онцлов.

Босго нэмэгдүүлэх боломж

НӨАТ-т жижиг аж ахуйн нэгжүүдийг хамруулахгүй байх үндсэн шалтгаан нь татварт хамрагдах, татвар төлөх зардал нь тэдгээрт ихээхэн дарамт болж байдаг. Нөгөө талаас татвар нэмэгдсэн үнээр борлуулалт хийх нь өрсөлдөх чадварыг бууруулах эрсдэлтэй аж. НӨАТ төлөгчөөр бүртгэх босгыг тооцоолохдоо НӨАТ-ын орлогод их хэмжээгээр нөлөөлөлгүйгээр татвар хураах болон татвар төлөх зардлыг хамгийн бага хэмжээд хүртэл бууруулах нь зүйтэй гэж дэд сайд С.Пүрэв өгүүлсэн юм. Түүнчлэн босгыг тухайлсан үйл ажиллагааны чиглэл, салбараар тогтоох боломжтой тул салбарыг тусгайлан бүртгэх боломжтой юм байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг мөрдөж эхэлснээс хойш босго хэмжээг 10 сая төгрөгөөр тогтоож өнөөг хүртэл 14 жил өөрчлөлт оруулаагүй. Уг 10 сая төгрөгийн суурийг эдийн засгийн нөхцөл байдал, тухайлбал бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдуулан эргэн харах шаардлагатай байгаа аж. Учир нь нэмэгдсэн өртгийн албан татвар нь импортлох, экспортлох, дотоодод үйлдвэрлэсэн болон борлуулсан бүхий л төрлийн бараанд ногдог бөгөөд 1998 онд борлуулж байсан бүтээгдэхүүний үнэ 2011 он хүртэл тодорхой хэмжээгээр өөрчлөгдсөн. Сангийн яамнаас 1998 оны 10 сая төгрөгийн бараа 2011 онд хэдэн төгрөгийн бараатай тэнцэх талаар инфляцитай уялдуулсан тооцоолол болон НӨАТ төлөгчдийн борлуулалтын орлогод үндэслэн хэд хэдэн хувилбараар холбогдох судалгааг хийжээ. Үүнд үндэслэн, Монгол Улсын нийт эдийн засгийн болон инфляцийн өсөлттэй уялдуулахын зэрэгцээ жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилтын хүрээнд нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг 50 сая хүртэл төгрөг болгон нэмэгдүүлэх боломж байгаа гэж үзэн, татварын хоёр дахь шатны шинэчлэлийн ажилд тусгахаар төлөвлөжээ.

Дээрх санал болгож буй 50 сая төгрөгийн босго нь ойролцоогоор 34 мянган ам.доллартай тэнцэнэ. Үүнийг дэлхийн бусад оронтой харьцуулахад энэ нь дундаж түвшин бөгөөд олон

Монгол Улсад нэвтрүүлсэн татваруудаас НӨАТ нь ОУВС, Дэлхийн банк, АХБ, БНСУ-ын KOICA, АНУ-ын USAID, Япон улсын JICA зэрэг байгууллагаас “олон улсын стандарт түвшинг хангасан бүтэцтэй, хэрэгжилтийн түвшин нь хангалттай сайн” гэсэн үнэлгээ авчээ.

► улсын түвшинтэй харьцуулан үзэх үндэслэлтэй хэмжээ аж. НӨАТ-ын босгын хэмжээг өөрчлөлгүй удсан, инфляцийн түвшинтэй харьцуулан тохируулахад ойролцоогоор 36 сая төгрөг болж байгааг харгалзан босгыг 35 сая төгрөгөөр тогтоож болох юм гэсэн хувилбар ч бий. Гэхдээ зөвхөн инфляци бус эдийн засгийн өсөлттэй уялдуулан одоогийн түвшинг 50 сая хүртэл нэмэгдүүлснээр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 60 орчим хувь нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх юм. Эдгээр татвар төлөгчид бүртгэл хөтлөх дарамт, зардлаас холдож, татвар хураалтын эрх бүхий байгууллага өөрийн хүч нөөцөө том татвар төлөгчдөд чиглүүлэх боломжийг нэмэгдүүлэх талтайг тус судалгаанд онцолжээ.

Олон улсын чиг хандлага

Олон улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас эрхлэн гаргадаг 2012 оны хэрэглээний татварын чиг хандлага эмхтгэлээс үзэхэд өнгөрсөн оны байдлаар дэлхийн 150 гаруй улс НӨАТ нэвтрүүлжээ. Дэлхийн нийт татварын орлогын 20 орчим хувийг энэ татвараар цуглуулсан байна. Ажил гүйлгээний бүхий л шатанд татварыг ногдуулж, худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг хасагдуулах агуулга нь бизнес эрхлэгчдийн зүгээс ихээхэн дэмжлэг авч, өмнө нь гүйлгээний татвартай байсан Европын орнуудад НӨАТ-ыг эрс хурдацтай нэвтрүүлсэн байна.

Шинэ Зеландын загвар буюу Монгол Улсад нэвтрүүлсэн НӨАТ-ын загвар нь Европын загвараас хавьгүй илүү үр дүнтэй, ашигтай загварт тооцогддог. Татварын суурь буюу татвар ногдох өргөн хүрээ нь хувь хэмжээг бага байлгах боломжоор хангах бөгөөд НӨАТ-ын хувь хэмжээ нь Европын орнуудаас бараг хоёр дахин бага байдаг байна.

Ерөнхийдөө улс орнууд НӨАТ-ыг өөрсдийн нийгэм, эдийн засгийн бүтцэд тохируулан, сөрөг үр дагавруудыг аль болох бага байлгах үүднээс түүний хувь хэмжээ, хамрах хүрээ, тайлангийн хугацаа, татвар тооцох механизмыг нарийн тооцоолж сонгодог. Иймээс тухайн татварын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол ч харилцан адилгүй байна. Тухайлбал НӨАТ-ын хувь хэмжээ Сингапурт долоон хувь, Япон, Канадад таван хувь байхад Дани, Швед зэрэг улсад 25 хувьтай байна. Цөөн хэдэн орныг эс дурдвал дэлхийн бусад орнуудад НӨАТ-ын хувийг ихэвчлэн хоёр оронтой тоогоор илэрхийлдэг. Манай хоёр хөршид стандарт хувь нь 17-18

хувьтай байгаа юм. Энэ татварыг ихэнх орнууд “төсвийн орлогыг бүрдүүлэгч хэрэгсэл” болгон нэвтрүүлдэгийн сацуу түүний бусад давуу талыг харгалзан үздэг байна.

Худалдааны татвар

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Э.Батбаяр “НӨАТ болон худалдааны албан татварын харьцуулсан дүгнэлтээр НӨАТ-т тодорхой хэмжээний дутагдалтай ч худалдааны албан татварыг бодвол давуу тал их” гэв. НӨАТ-ыг худалдааны албан татвараар солих нь татварын хууль эрх зүйн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй бөгөөд Монгол Улсын эдийн засагт хөрөнгө оруулалт хийх сонирхлыг эрс бууруулах сул талтай аж.

“Ялангуяа татварын албаны түвшинд төдийгүй Монгол Улсын хэмжээнд бүртгэл мэдээллийн нэгдсэн цогц тогтолцоо бүрдэж чадаагүй, хяналтын систем харьцангуй сул, бэлэн бус төлбөр тооцооны систем сайн хөгжөөгүй нөхцөлд НӨАТ-ыг худалдааны албан татвараар сольсноор уг татвараас зайлсхийх, зугтах, нуун дарагдуулах явдалд хяналт тавихад маш хүндрэлтэй болох тул худалдааны албан татварын орлого буурч, далд эдийн засгийн хэмжээ нэмэгдэх магадлалтай” хэмээн Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт тайлбарласан юм.

Монгол Улсад орчин үеийн татварын төрлүүдээс НӨАТ нь харьцангуй татвар төлөгчдөд энгийн ойлгомжтой байдлаар хэрэгжиж хэвшсэн татварын нэг. НӨАТ-ын тооцоолол, тайлан гаргах үйл ажиллагааг татвар төлөгчдийн дийлэнх хувь нь хэрэгжүүлж дадсан, татварын албаны зүгээс ч олон арга хэмжээг хэрэгжүүлэн, НӨАТ-ын тайлан хүлээн авалт, падаан боловсруулалтыг цахим хэлбэрт шилжүүлж, холбогдох програм хангамжийг боловсруулж нэвтрүүлсэн байна. Татвараас зугтах, зайлсхийгчдэд хяналт тавих мэдээллийн сан үүсгэн үйл ажиллагаандаа ашиглах, НӨАТ-ыг хөгжүүлэх талаар маш их хөрөнгө зарцуулж тодорхой үр дүнд хүрч байгааг салбарынхан онцолсон юм.

Худалдааны татварын хамгийн том сул тал нь каскад /цуваа/ нөлөөлөл байдаг. Энэ нь нэмэгдсэн өртөгт бус бараа үйлчилгээнд шууд ногддог тул үнийн өсөлтийг дэмжих сөрөг талтай аж. НӨАТ-ын хувьд нэмүү өртөгт ногдож буй тул дээрх нөлөөлөл байхгүй. Олон улсын жишгээр эдийн засгийн эрүүл, хурдан үйлчлэх бодлого эрэлхийлж буй нөхцөлд НӨАТ-ыг худалдааны татвараар сольж орлогоо бууруулах нь тохиромжтой шийдэл биш гэж үздэг байна. ■

ИХ
KHARANGA


ИИЧБРЭНД



ИИЧ ГАЗ



Турк улсад үйлдвэрлэгдсэн

Хаяг:
ИХ ХАРАНГА ХХК оффис
Энхтайвны өргөн чөлөө 18/1
Баянгол дүүрэг 5-р хороо
Монгол улс, Улаанбаатар хот

Вэб хаяг:
www.ikharanga.mn
Утас:
(976)-7010-0156
9111-6587, 9111-6586
Факс:
(976)-11-680437
И-мэйл:
ilchgaz@kharanga.mn

ТООНЫ ХЭЛЭЭР

ЧИНГИС БОНД

Бондын хүү, эргэн төлөлттэй холбоотойгоор улсын төсвөөс шаардагдах эх үүсвэр (сая.ам.доллараар)

	Жилүүд									
	1	2	3	4	5	6	7	8	9	10
500,0 сая доллар хүү	20.6	20.6	20.6	20.6	20.6					
1,0 тэрбум доллар хүү	51.2	51.2	51.2	51.2	51.2	51.2	51.2	51.2	51.2	51.2
500,0 сая доллар төлбөр	-	-	-	-	500,0					
1,0 тэрбум доллар төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	1,000
Нийт дүн сая доллар	71,8	71,8	71,8	71,8	571,8	51,2	1,2	51,2	51,2	1051,2
Нийт дүн (тэрбум төгрөг)	100,4	100,4	100,4	100,4	800,0	71,6	71,6	71,6	71,6	1,470

Хэмжээ	500,0 сая ам.доллар	1,0 тэрбум ам.доллар	Нийт дүн
Хугацаа	5 жил	10 жил	
Хүүгийн хэмжээ	4,125 %	5,125 %	-
Хоногт төлөх хүү /ам.доллараар	56,506.8	140,410.9	196,917.7
Хоногт төлөх хүү /төгрөгөөр/ 1\$=1398 ₮	78,996,506.4	196,294,438.2	275,290,944.6
Жилд төлөх хүү /ам.доллараар	20,624,982.0	51,249,978.5	71,874,960.5
Жилд төлөх хүү /төгрөгөөр/ 1\$=1398 ₮	28,833,724,836.0	71,647,469,943.0	100,481,194,779.0
5 жилд төлөх хүү /ам.доллараар/	103,124,910.0	-	103,124,910.0
5 жилд төлөх хүү /төгрөгөөр/1\$=1398 ₮	144,168,624,180.0	-	144,168,624,180.0
10 жилд төлөх хүү /ам.доллараар/	-	512,499,785.0	
10 жилд төлөх хүү /төгрөгөөр/1\$=1398 ₮	-	716,474,699,430.0	
5 жилийн эцэст төлөх үндсэн өр/ам.доллар/	500,000,000.0		
5 жилийн эцэст төлөх үндсэн өр /төгрөгөөр/	699,000,000,000.0		
5 жилийн нийт төлбөр /хүү+ үндсэн өр/ \$	603,124,910.0		
5 жилийн нийт төлбөр /хүү+ үндсэн өр/ төг	843,168,624,180.0		
10 жилийн эцэст төлөх үндсэн өр /ам.доллар/		1,000,000,000.0	
10 жилийн эцэст төлөх үндсэн өр /төгрөгөөр/		1,398,000,000,000.0	
10 жилийн нийт төлбөр /хүү+ үндсэн өр/ \$		1,512,499,785.0	
10 жилийн нийт төлбөр /хүү+ үндсэн өр/ төг		2,114,474,699,430.0	
Нийт төлбөр /ам.доллараар/		2,115,624,695.0	
Нийт төлбөр /төгрөгөөр/		2,957,643,323,610.0	
		/хоёр их наяд, есөн зуун тавин долоон тэрбум, зургаан зуун дөчин гурван сая, гурван зуун хорин гурван мянга/	

Бондын хүүгийн болон үндсэн төлбөр

Чингис бондын хүүгийн төлбөрт жилд 75.0 сая ам.доллар буюу 108.0 тэрбум төгрөг, өдөрт 208.3 мянган ам.доллар буюу 300.0 сая төгрөг төлнө.

“Чингис” бондоор санхүүжүүлэх төслүүд

Төслийн нэр	Чингис бондоос санхүүжүүлэх хэмжээ, сая ам.доллар	Засгийн газрынтогтоолын дугаар
Таванолгойн цахилгаан станц” төсөл	50.0	80
“Гудамж” төсөл	200.0	81
“Шинэ төмөр зам” төсөл	200.0	82
“Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбох” төсөл	404.2	96
Нийслэлийн орон сууцны дэд бүтцийг сайжруулах төсөл	141.8	118
Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарны техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх	68.8	126
Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр	27.7	141
Өвлийн хүлэмж барих	17.4	141
Ноосон бүтээгдэхүүний үйлдвэр	45.0	141
Оёмол бүтээгдэхүүний салбар	13.5	141

Улс орнуудын зэрэглэл ба Засгийн газрын бондын хүү

	Улсын нэр	Улсын өр ДНБ(%) 2011	Улсын өр ДНБ(%) 2012	S&P Зэрэглэл	5 жилийн хугацаатай бондын хүү	10 жилийн хугацаатай бондын хүү
1	Герман	81.5	78.8	AAA	0.402%	1.373%
2	Хонконг	33.8	33.1	AAA	0.530%	1.164%
3	Нидерланд	66.2	70.1	AAA	0.570%	1.690%
4	Дани	46.4	51.3	AAA	0.668%	1.477%
5	Их Британи	82.4	88.374	AAA	0.823%	1.880%
6	Канад	84.9	84.6	AAA	1.350%	1.930%
7	Австрали	22.8	24	AAA	2.763%	3.267%
8	Австри	72.2	73.9	AA+	0.060%	1.739%
9	Франц	86.2	89	AA+	0.731%	1.891%
10	АНУ	102.9	106.5	AA+	0.837%	1.968%
11	Катар	31.4	29.5	AA	1.540%	2.870%
12	Япон	229.7	235.8	AA-	0.417%	0.877%
13	Хятад	25.8	22	AA-	3.200%	3.470%
14	Чили	9.9	10	AA/A+	5.030%	5.090%
15	Чех	41.4	43.9	AA/AA-	0.920%	1.580%
16	Малайз	52.5	53.1	A/A-	3.080%	3.080%
17	Польш	55.3	55.6	A	2.885%	3.332%
18	Мексик	43.8	42.8	A-/BBB	4.240%	4.720%
19	Бразил	66.1	65	A-/BBB	9.390%	9.970%
20	Өмнөд Америк	38.7	39.9	A/BBB+	5.630%	6.410%
21	Тайланд	41.6	44.3	A-/BBB+	2.840%	3.290%
22	Перу	21.6	20.7	BBB+	2.700%	4.030%
23	Итали	120.1	123.3	BBB+	2.787%	3.921%
24	Испани	68.4	79	BBB+	2.948%	4.196%
25	ОХУ	9.6	8.3	BBB+/BBB	6.150%	6.650%
26	Колумб	34.6	32.3	BBB+/BBB-	5.610%	6.080%
27	Турк	39.4	36	BBB-/BB	5.740%	6.190%
28	Болгар	17	21.3	BBB	2.000%	3.106%
29	Исланд	99.1	97.3	BBB-	5.240%	6.240%
30	Энэтхэг	68	67.5	BBB-	7.274%	7.330%
31	Филиппин	40.4	40.1	BB+	2.730%	3.380%
32	Румын	32.9	34.2	BB+	4.601%	4.901%
33	Унгар	80.4	76.2	BB+	4.610%	5.000%
34	Индонез	25	23.2	BB+	4.960%	5.660%
35	Португал	106.7	112.3	BB	3.981%	5.225%
36	Монгол			BB-	4.750%	5.125%
37	Вьетнам	37.9	37.3	BB-	8.260%	9.180%
38	Пакистан	60.1	61.7	B-	10.460%	11.280%

Эх сурвалж: ЭЗХЯ, МУХАҮТ

БОДЛОГЫН СУДАЛГАА



ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭЧЛЭЛ

2013 оны хоёрдугаар сараас эхлэн СЭЗДС-ийн багш нар “Монголын эдийн засаг, санхүүгийн зах зээлд үзүүлэх Хятад улсын эдийн засгийн нөлөө” сэдэвт судалгааны ажлыг П.Гантөмөр Б.Мөнхзаяа, Ц.Чулуунцэцэг, Т.Анарболд, Э.Элдэв-Очир, С.Дашдорж, Б.Номун нар хамтран төсөлт судалгааг боловсруулжээ. Тус судалгааны хэсэгт багтсан өмнөд хөрштэй холбоотой эдийн засгийн шинэчлэлтийг онцлон хүргэж байна. Манайхаас даруй 860 дахин том эдийн засагтай өмнөд хөрш Японыг “жийж”, АНУ-тай өрсөлдөж буй. Хятадын эдийн засаг сүүлийн 30 жилд дунджаар 9.9 хувиар тасралтгүй өсчээ.

1. Дэлхийн зэсийн нийт хэрэглээний 40 хувийг эзлэх БНХАУ-ын барилгын салбар дахь бэрхшээлээс шалтгаалж зэсийн үнэ 18, нүүрснийх 38 хувиар тус тус буурах магадлал буйг судалгаанд онцолжээ. Энэ онд өмнөд хөршийн эдийн засагт дорвитой сэргэлт гарахгүй нь. Түүнчлэн Хятадын эдийн засгийн удаашрал Монголын эдийн

засагт хүчтэй нөлөө үзүүлэхийг анхааруулжээ. Тиймээс бэлтгэлтэй байхыг сануулсаар.

2. Хятадын хадгаламжийн хэмжээ 2010 он гэхэд ДНБ-ий 53.9 хувьтай тэнцүү хэмжээнд хүрсэн нь дотоодын хөрөнгө оруулалтыг хурдацтай өсөхөд эерэг нөлөө үзүүлжээ. Энэ нь урд хөршийг дэлхийн эдийн засагт нөлөө бүхий

зээлдүүлэгч болгосон. Шинжээчдийн үзэж буйгаар Хятадын эдийн засгийн өсөлтөд нөлөөлж буй бас нэг хүчин зүйл бол үйлдвэрлэлийн өсөлт. Мөн гаднын өндөр технологи болон ноу хау-г богино хугацаанд өөрийн болгож чаддаг нь Хятадын үйлдвэрлэлийн бүтээмжийг хурдацтай өсгөх хөшүүрэг болсныг судалгаанд дурджээ. ▶

3. Хятадын ДНБ 2011 онд 7.2 их наяд ам.доллар байсан нь АНУ-ын эдийн засгийн тэн хагастай тэнцэж байгаа юм. Нэг хүнд ногдох ДНБ-ий хувьд 5460 ам.доллар. Энэ нь Япон улсын нэг хүнд ногдох ДНБ-ий 12, АНУ-ын 11 хувьтай тус тус тэнцэх хэмжээ. Судалгаанд өгүүлснээр Хятадын эдийн засаг 2016 он гэхэд АНУ-ыг гүйцэж түрүүлэх таамаг гарчээ.

4. 33 жилийн өмнө буюу гадаад худалдаагаа нээлттэй болгохоос өмнө Хятадын эдийн засгийн бодлого зогсонги, хяналт нь төвлөрсөн, дэлхийн эдийн засгаас тусгаарлагдсан байв. Тэгвэл 1979 онд анх гадаад худалдаа болон гаднын хөрөнгө оруулалтыг нээлттэй болгосноор тус улс дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй орны тоонд багтаад байна.

5. Хятад нь гадаад худалдааны чадавхтай улсуудын тоонд орж, дэлхийн хоёр дахь том эдийн засагтай улсаар тодроод буй. Хамгийн том экспортлогч болоод импортлогч. Мөн дэлхийн гадаад худалдааны хоёр дахь том төв бөгөөд үйлдвэрлэгч. Өнөөдөр гадаад валютын нөөцөөрөө дэлхийд тэргүүлж байна. Өнгөрсөн оны байдлаар тус улсын гадаад валютын нөөц 3.29 их наяд ам.долларт хүрчээ.

6. 2008 оны санхүү, эдийн засгийн хямрал нь Хятадын эдийн засагт ихээхэн нөлөө үзүүлсэн ч маш хурдан сэргэсэн. Тухайн үед экспорт, импорт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал царцаж, ДНБ-ий өсөлт удааширч, сая сая Хятад ажилчин ажилгүй болсныг бид мэдэх билээ. Хятадын эрх баригчид эдийн засгаа аврахын тулд нийт 586 тэрбум ам.долларыг зарцуулсан байдаг. Уг мөнгөөр банкны зээлдүүлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд мөнгөний бодлогоо зөөллөж, бүх төрлийн хэрэглээг дэмжиж ажилласан. Үүний дүнд Хятадын эдийн засаг

дэлхийн эдийн засгийн хямралын огцом уналтын нөлөөг сааруулж чаджээ.

7. 2008-2011 оны хооронд Хятадын эдийн засгийн өсөлт дунджаар 9.6 хувьтай байв. Зарим эдийн засагч Хятадыг цөөн хэдэн жилийн дотор АНУ-ыг гүйцэж дэлхийн тэргүүлэгч эдийн засагтай улс болно гэж таамаглаж байгаа юм. Гэвч АНУ-ын нэг хүнд ногдох ДНБ Хятадтай харьцуулахад асар өндөр байгаа билээ.

8. Хятад эдийн засгийн хурдацтай өсөлтөө хадгалахын тулд төрийн бодлогыг оновчтой болгож шинэчлэх шаардлагатай байгаа юм. Түүнчлэн эдийн засгийг тэнцвэржүүлэх тал дээр бараа, үйлчилгээ экспортлохоос илүүтэйгээр өөрийн улсын хэрэглээг дэмжсэн бодлого баримтлах хэрэгтэй аж. Хятадын эдийн засагт нөлөөлөх бэрхшээлүүд олон бий. Жишээлбэл, хүн амын тархалт, орлогын өсөлт, нийгмийн эрүүл мэндийн сүлжээний хөгжөөгүй байдал, байгаль орчны бохирдол, байгалийн нөөцийн хомсдол, эдийн засагт нөлөөлөх төрийн хэт оролцоо хэрхэн хувьсахаас өмнөд хөршийн хэтийн хөгжил улам тодорхой болох нь.

9. Хятадын худалдааны болон хөрөнгө оруулалтын эрх чөлөө, эдийн засгийн шинэчлэл зэрэг нь өсөлт, хөгжлийн үүдийг нээжээ. Хятадын экспортын хэмжээ 1979-2011 оны хооронд 14 тэрбум ам.доллараас 1.9 их наяд ам.доллар болтлоо өсчээ. 1990-2011 оны хооронд экспортын жилийн дундаж өсөлт 19.5 хувь, импортын жилийн дундаж өсөлт 18.4 хувь байсан байна. Хятад нь дэлхийн хоёр дахь том газрын тос хэрэглэгч. 2011 онд өдөрт дунджаар 9.8 сая баррель газрын тос хэрэглэдэг байсан бол 2035 он гэхэд энэ үзүүлэлт 16.9 сая баррель болох аж. Хятадын 500 үйлдвэрийн 50 хувь, 500 үйлчилгээний салбарын

61 хувийг тус тус төрийн өмчит компаниуд эзэлж байна.

10. Урд хөршийн банкны систем бараг бүхлээрээ Засгийн газрын удирдлагад байдаг. Энэ нь аж үйлдвэрт чиглэсэн хөрөнгийн урсгалыг удирдаж Хятадын эдийн засгийн хөгжлийг дэмжихэд оршдог байна. Мөн төрийн өмчит компаниуд банкнаас ихэвчлэн хөнгөлөлттэй зээл авдаг бөгөөд төрийн өмчийн бус компаниудтай харьцуулахад бага хүү төлдөг аж. Судалгаагаар 2009 онд банкны нийт зээлийн 85 хувь буюу 1.4 их наяд ам.долларын зээлийг төрийн өмчит компаниуд эзэлж байжээ. Түүнчлэн Засгийн газраас хадгаламжийн хүүг маш багаар тогтоодог бөгөөд ихэвчлэн инфляцийн түвшнээс багаар тогтоодог байна. Энэ нь эргээд компаниудын эх үүсвэрийн өртгийг бага байлгах зорилготой холбоотой аж.

11. Манай урд хөрш өөрийн валютыг хэт хэлбэлзэлтэй байхыг хүсдэггүй. Иймд ханшийг тогтоосон түвшинд нь барих үүднээс их хэмжээний ам.доллар худалдаж авдаг. Хэдийгээр эдийн засгийн шинэтгэл хийснээс хойш юанийн ам.доллартай харьцах ханш бодит дүнгээр 40 орчим хувиар өссөн боловч бага үнэлгээтэй хэвээр байна.

12. Хятадын эдийн засаг сүүлийн хэдэн жил хурдацтай хөгжсөн ба ойрын жилүүдэд ч эдийн засгийн эрүүл өсөлттэй байна хэмээн таамаглаж байна. Гэхдээ эдийн засагчид Хятадыг эдийн засагтаа томоохон хэмжээний шинэтгэл хийсэн тохиолдолд л энэ амжилтад хүрнэ хэмээж байгаа. Хэрэв эдийн засгийн реформ бүтэлгүйтвэл ирээдүйн өсөлтөд сөргөөр нөлөөлөх талтайг судалгаанд өгүүлжээ. Шинжээчдийн үзэж буйгаар Хятадын өнөөгийн баримталж буй эдийн засгийн загвар нь сөрөг эдийн засгийн нөхцөлийг бий болгоно гэж анхааруулсан байна. ■

АСУУДАЛ

НҮҮРСНИЙ УНАЛТЫН ЦЭГ

Б.БАЯРТОГТОХ

“Эрчим хүчний зорилгоор ашиглах нүүрсний хэмжээ Хятадад гурван хувиар нэмэгдэнэ. Тиймээс нүүрсний ирээдүйн дүр зураг өөдрөг байна. Хэдий дотоодоос хэрэгцээгээ хангах ч гаднаас нүүрс худалдан авах болно” гэж Маттью Поттел хэллээ.



Уул уурхайн салбарт үнийн уналт газар авсаар. Үүний тод жишээ нь нүүрс. Хил дээрх нүүрсний экспорт зогсонги байдалд орсон нь төсвийн орлогоос гадна иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлөв. Энэ нь уул уурхайд хэт найдсан монголчуудад санхүүгийн шинэ хямарлыг даллаж байна. Уг зах зээлийг тойрсон ханган нийлүүлэлт саарч, нүүрсний компаниуд алдагдал хүлээгээд эхэллээ.

Нүүрсний зах зээлд хошуурсан гаднын хөрөнгө оруулалт царцаж, үндэсний томоохон төслүүд “хөшөө” болж мэдэх нь. Нүүрсний үнэ уруудаж, Тавантолгойн экспорт эргэлзээ төрүүлснээр төсөвт тооцсон 55 тэрбум төгрөгийн орлого он дамжих дүр зураг харагдаж эхлэв. “Тавантолгой бол монголчуудыг 250 жил тэжээх хэмжээний нөөцтэй нь тогтоогдсон” хэмээн ҮХАА-ын сайд Х.Баттулга өгүүлсэн. Нүүрсний үнэ ийн газардсан нь олон асуудлыг араасаа дагуулж байна. Энэ онд нийт 34.8 сая тонн нүүрс экспортолж, 466 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр баталсан. Гэвч эхний таван сарын байдлаар дөнгөж

6.3 сая тонн нүүрс экспортлоод байна. Үүнтэй зэрэгцэн төсвийн орлого тасалдах нь нэгэнт тодорхой болсон тул Сангийн яамнаас тодотгол хийх асуудлыг хөндөөд эхэлж. Тус яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Ганбат “Төсвийн орлого 335.6 тэрбум төгрөгөөр тасарсан” гэлээ. “Чингис” бондоор төсвийн алдагдлыг нөхөж байна гэсэн яриа ч эдийн засагчдын дунд дэгдэх боллоо.

Урд хөршийн эдийн засгийн өсөлт саарсан нь түүхий эдийн үнэд нэрмээс болж, нүүрсний ханш уруудсаныг судлаачид тэмдэглэв. Энэ оны байдлаар олон улсын зах зээлд эрчим хүчний нүүрсний дундаж үнэ 34 хувиар унажээ. Коксжих нүүрсний үнэ сүүлийн гурван жилийн хамгийн доод цэгтээ хүрээд байгаа. Өнөөдрийн байдлаар нэг тонн нүүрс 40 ам.доллартай тэнцэж байна. Шинжээчдийн хэлж буйгаар 2014 оны сүүлч хүртэл нүүрсний үнэ сэргэхгүй нь. Хэрэв бодит байдал жил дамнан үргэлжлэх аваас уул уурхайд түшиглэсэн Монголын эдийн засаг хэцүүдэх дүр зураг бууж байна.

Мөрөөдөл

БНХАУ-ын “Argus Media” компанийн нүүрсний үнийн шинжээч Виллиам Ванг “Нүүрсний зах зээлд богино хугацаанд сэргэлт гарахгүй. Хятадын Засгийн газраас нүүрсний зах зээлтэй холбоотой хууль эрх зүйн орчныг чангатгаж байгаа. Энэ нь байдлыг улам хүндрүүлнэ. Ойрын хугацаанд Хятадын гангийн үйлдвэрлэлд ч дорвитой ахиц дэвшил алга” хэмээн Улаанбаатар хотноо өнгөрсөн сард болсон “Coal-trans Mongolia-2013” чуулганы үеэр өгүүлсэн. Түүний хэлснээр нөхцөл байдал буруу тийшээ эргэвэл Тавантолгойн IPO хойшлох нь эхний хэрэг. Бидний мөрөөдөж буй 1072 ширхэг хувьцааны ногдол ашиг улам холдоно гэсэн үг.

Дэлхийн эрчим хүчний анхдагч хэрэгцээний 30 хувийг хангах нүүрс Монголын эдийн засгийг хөдөлгөх хүчний нэг. Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүү “2015 оноос Хятадын эдийн засаг өндийж, нүүрсний ▶

үнэ сэргэнэ гэж судлаачид үзэж байгаа. Үнийн бууралтад хэд хэдэн зүйл нөлөөлсөн. Тухайлбал, Хятадад нүүрсээ экспортолдог компаниуд нэмэгдэж, өрсөлдөөн ширүүсч буй. Өмнө нь манай улс Хятадын нүүрсний импортод нэгдүгээр байрт ордог байсан бол одоо ОХУ, Канад улс хүч түрж орж ирсэн” гэв. Нүүрсний зах зээлд шинэ өрсөлдөгчид тодрохын хэрээр Монголын орон зай хумигдах шалтгааныг төр, хувийн хэвшил хамтдаа хайх цаг болсныг дээрх баримт өгүүлнэ.

Хүлээлт

Монголд нүүрсний үнээс үүдэлтэй хямрал хүрээгээ тэлэх нь тун эрсдэлтэй. Энэ нь эдийн засгийн өсөлтөд сөргөөд нөлөөлөөд зогсохгүй төсөвт хүндрэл учруулна гэж Дэлхийн банкаас анхааруулсан. Үнээс хамаарсан санхүүгийн доройтол Монголын арилжааны банкинд ч давхар эрсдэл үүрүүлэх магадлалтай аж. “Өнгөрсөн хорин жилд дэлхий дахин “уул уурхайн супер мөчлөг” гэгчийг үүсч, хөгжихийг харсан. Ази, Латин Америк, Зүүн Европын зарим улсад аж үйлдвэрийн салбар хурдацтай өсөхтэй зэрэгцээд металл, эрчим хүчний ашигт малтмалын эрэлт хэрэгцээ нэмэгдсэн. Технологийн дэвшлийн ачаар үелэх системийн бараг бүх элементийн эрэлт өссөн” гэж Дэлхийн банкаас гаргасан Монголын эдийн засгийн тоймд өгүүлжээ.

“Барклэйс Капитал” компанийн тооцоогоор эрдэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл дэлхийн хэмжээнд хурдацтай хэвээр өсөх тул үнэ буурна хэмээн мэдэгдсэн юм. Нүүрс стратегийн бараа боловч бүс нутгийн шинж чанартай гэх. Дэлхийн нүүрсний ассоциацийн статистик мэдээгээр дэлхийн нүүрсний хэрэглээ 7.7 тэрбум тонн. Үүний 967 сая тонн нь коксжих нүүрс. Тэгвэл дээрх хэрэглээний тэн хагас буюу 3.4 тэрбум тонныг “уух” урд хөршийн эрэлт огцом буурахгүй гэж “PwC” компанийн Монгол дахь салбарын гүйцэтгэх захирал Маттью Поттел онцлов. “Global Raw Material Group”-ийн тооцоолсноор, дэлхийн уул уурхайн үйлдвэрлэлийн 29 хувь нь Хятадад ногдож байна.

Горьдлого

Нийлүүлэлтээс давсан эрэлтийн дүнд коксжих нүүрсний зах зээлийн үнэ сүүлийн 20 жилд дөрөв дахин өссөн байдаг. Үүнтэй зэрэгцэн эрчим хүчний нүүрсний үнэ хоёр дахин нэмэгдсэн билээ. Хятадын нүүрсний импорт 2015 он хүртэл 170 сая тонн хүртэл өсөх хандлагатай байгаа бол Энэтхэгийнх 150 сая тоннд хүрэх төлөв бий. Уг үзүүлэлт биелэх эсэх нь урд хөршийн эдийн засгийн өсөлтөөс шууд хамаарах юм. Урд хөршийн эдийн засаг энэ онд 8.2 хувиар өсөх бөгөөд ирэх онд уг өсөлтөө хадгална хэмээн Азийн хөгжлийн банкны таамаглалд дэвшүүлжээ. Гэхдээ өмнөд хөршийн эдийн засгийн сэргэлт дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамаарах бололтой. Юутай ч дэлхийн нүүрсний жилийн эрэлт ирэх таван жилд 1.6 тэрбум тонноор нэмэгдэх төлөв байгаа билээ.

Хятад 2015 он хүртэл нийтдээ 170 сая тонн дулааны нүүрс импортлох тохиолдолд нүүрсний үнэд бага зэргийн сэргэлт авчирна гэж таамаглаж буй. Хэдийгээр өмнөд хөршийн гангийн үйлдвэрлэл багассан ч бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэх хандлагатай тул коксжих нүүрсний эрэлт өснө гэж Хятадын “Фенвэй Энержи” зөвлөх компани онцолжээ. Тухайлбал, нүүрсний эрэлт 2015 онд 50 сая тонноор өсөх урьдчилсан таамаг гарчээ. Энэ нь Ази тивийн нүүрсний эрэлтэд шинэ хуудас нээнэ хэмээн тодотгож буй. БНХАУ өнгөрсөн 30 жилд урд бүсээ хөгжүүлсэн бол ирэх 30 жилд хойд бүсээ хөгжүүлэх зорилт тавьжээ. Хойд бүсээ хөгжүүлэх уг шийдвэр Монголын нүүрсний зах зээлд хөл дээрээ босох том нөхцөл болох талаар судлаачид тэмдэглэж байна.

Боломж

“Эрчим хүчний зорилгоор ашиглах нүүрсний хэмжээ Хятадад гурван хувиар нэмэгдэнэ. Тиймээс нүүрсний ирээдүйн дүр зураг өөдрөг байна. Хэдий дотоодоос хэрэгцээгээ хангах ч гаднаас нүүрс худалдан авах болно” ▶

График-1. Монголын нүүрсний экспортын урьдчилсан тооцоолол




График-2. Нүүрс экспортлогч компаниудын зах зээлд эзлэх хувь (2017 он)





График-3. Хятадын коксжих нүүрсний экспортын зах зээлд Монголын эзлэх хувь (2015 он)



Эх сурвалж: Монгол Улсын нүүрсний салбарын зах зээлийн тойм судалгаа

▶ гэж Маттью Поттел хэллээ. Түүний хэлснээр урд хөршийн эрчим хүчний хэрэгцээ ирэх 20 жилд 50 хүртэлх хувиар нэмэгдэх бөгөөд энэ нь нүүрсний хэрэглээ 17 хувиар өсөх хөшүүрэг болох аж.

Нөгөөтэйгүүр нэг автомашин үйлдвэрлэхэд 700-800 кг ган ашигладаг. Тэгвэл урд хөршид энэ онд багтан автомашины 30 үйлдвэр үүдээ нээх нь. Энэ нь нүүрсний зах зээлд шинэ эрэлт үүсгэнэ хэмээн Маттью Поттел тэмдэглэсэн. Дэлхийн хүн ам өсөн нэмэгдэхийн хэрээр нөөцийн хомсдол үүснэ. Энэ нь түүхий эдийн үнэд тал

засах шалтгаан болно гэж судлаачид тайлбарлаж байгаа.

“2005-2030 онд дэлхийн эдийн засагт эрчим хүчний хэрэглээ 1.5 хувиар нэмэгдэх бол Ази, Номхон далайн бүсэд жилд даруй 2.4 хувиар өсөхөөр байна” гэж Ази, Номхон далайн бүсийн товчооны захирал Ажей Чиббер онцлов.

Үүлний цаана нар хэзээд байгаа

Америк, Канад, Өмнөд Африк, Австрали байгалийн баялгаараа өндийж, эдийн засаг нь хөлжжээ.

Тэдний зам өнөөдөр монголчуудын зам болоод буй.

Ашигт малтмалын газрын судалгаагаар 2025 он гэхэд Монгол Улс 100 сая тонн нүүрс олборлож, 80 сая орчим тонныг экспортолж, 16-18 сая тонныг дотоодын хэрэгцээнд эрчим хүч болгон ашиглана гэсэн тооцоо хийжээ. Тухайлбал, 10 жилийн дараа Хятадын коксжих нүүрсний 70 хувь нь буюу 40 сая орчим тонныг Монгол Улс нийлүүлэх боломжтой аж. Эцэст нь Европыг нөмөрсөн хямралын сүүдэр арилж гэмээнэ Хятадын эдийн засгийн өсөлт хурдаа авч, Монголын нүүрс дахин моодонд орох болой. ■

ТОМИЛОЛТ

БАЯН-АЙРАГИЙН АЛТНЫ УУРХАЙ БА ЭСЭРГҮҮЦЭЛ

Д.БЭХЭЭ

Завхан аймгийг замын хүн саатмаар нутаг гэлцдэг. Энэ нь ч үнэний ортой. Олон гол мөрөн, нуур, өндөр уул, толгод, тал хээр, болон говийн элсэн манхан бүгд цогцолсон үзэсгэлэнт газруудтай. Алтны ганцхан том төслийг эс тооцвол одоогоор уул уурхайн том гар хүрч очоогүй байгаль эх нь онгоноороо буй цөөхөн аймгийн нэг. Харин сүүлийн үед бас л газар дороо баялагтай болох нь илэрч, холын хүмүүсийн шуналыг хөдөлгөхөөс гадна алтны Баян-Айраг төсөл бараг л 90-ээд оноос эхэлж дуулдсаар өнөөдөр уурхай болох түвшинд ажиллаж байгаа юм. Хэл ам, тэмцлийн дунд явж буй тус уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан сурвалжлахаар манай сэтгүүлийн баг Завхан аймгийг зорьсон билээ.

Завхан аймгийн Дөрвөлжин сумын төвөөс зүүн хойш 25-км-т Баян-Айраг ▶



Завхан аймаг, Дөрвөлжин сум, Баян-Айрагийн алтны уурхайн кэмп

► гэж уул бий. Нэрнээсээ ч ихийг өгүүлэх энэ уул нь тус сумын Цогт бригадын нутагт орших бөгөөд олон айлын өвөлжөө байдаг газар. Хэвлийдээ алт, мөнгө, зэс нуусан энэ уулыг манай өвөг дээдэс хэдийнэ мэдэж байсан төдийгүй “Баян-Айраг” хэмээн нэрлээд газрыг онгоноор нь үлдээх зорилгоор оршуулгын газар болгожээ. Тиймээс 10 гаруй жилийн өмнө хайгуулын үйл ажиллагаа явуулахын тулд олон лам нарыг хотоос авч очиж, тус газрыг аргадан олон хүний шарилыг өөр тийш шилжүүлж байсан билээ.

Ер нь уг төсөл 1990-ээд оноос эхэлж хайгуулын ажил нь үргэлжилсээр өнөөдөр ордыг уурхайн түвшинд ашиглах бэлтгэл ажлыг хийж байна. Завхан аймгийн анхны уул уурхайн том төсөл гэж нэрийдэхэд хүргэсэн Баян-Айрагийн төсөл дардан замаар давхиад өнөөг хүрсэнгүй. Орон нутгийн иргэдийн эсэргүүцэл хэл амтай тулгарч, түүнийг даван туулахын төлөө хэлэлцээрийн ширээний ард сууж, үг хэлээ нутгийн иргэдтэй ололцохыг хичээн иржээ. Нөгөө талаар аав, ээж, өвөө, эмээгийнхээ шарилыг ухуулаад, дээр нь өвөлжөөгөө алдаад, төрсөн нутаг усаа уул уурхайн саварт сүйтгэгдэхийг нутгийн олон инээн хараад суух уу.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2011 оны долдугаар сарын 6-ны өдрийн хурлаар Баян айраг ордын исэлдсэн хүдрийн нөөцийг нийтдээ бодитой болон боломжтой гэсэн зэрэглэлээр 7,3 сая тонн нөөцтэй хэмээгээд металлын нөөцийг алтаар 14.98 тонн, мөнгөөр 81,5 тонноор тус тус хүлээн авчээ. “Баян-Айраг эксплорэйшн” компанийн тооцоолж буйгаар 6-7 жилийн хугацаанд алтны нөөцийг ашиглахаар төлөвлөсөн байна. Өнөөдрийн байдлаар газрын хөрсийг хуулах, баяжуулах үйлдвэрийн байрыг барьж эхлээд байгаа бөгөөд 400-гаад ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Аймаг, орон нутгийн засаг захиргаанаас уурхай нээх ашиглах зориулалтаар 4468,55 га талбай, уурхайн эдэлбэр газрын зориулалтаар 2896.65 га талбайг ашиглах зөвшөөрлийг тус тус авчээ.

Тус уурхай цахилгаан болон дулаан хангамжийн эх үүсвэрийг 6,6МВт суурилагдсан хүчин чадалтай байхаар

төлөвлөж, цахилгаан станц, дизель генератор, цахилгаан дамжуулах агаарын шугам гэсэн гурван төрлөөр судалгаа хийж буй. Харин усны асуудал нэлээд хүнд байгаа. Гэхдээ гарц олжээ. Баян-Айрагийн уурхай Завхан голоос усны хэрэглээгээ хангаснаар Завхан гол ширгэж, амьдрал дуусах тухай мэдээлэл нэг хэсэг цацагдсан. Тэгвэл тус компанийн мэргэжилтнүүд Монгол Улсын Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Усны тухай хууль болон холбогдох стандартыг мөрдөж ажиллахаа, мөн ажиллаж буйгаа ярьсан юм. Усны эх үүсвэрүүдийг судалж үзсэний үндсэн дээр газар доогуураа ямар нэг гол мөрөнтэй холбогдоогүй Эрдэнэхайрхан сумын Хайрханы хөндийгөөс гүний ус гарган авч ашиглахаар шийдвэрлэжээ. Шугамын хоолой татахын тулд аймгийн засаг захиргаанаас газрын зөвшөөрөл авч байж Хайрханы хөндийгөөс уурхай руу есөн км орчим цэвэр усны шугам татах юм байна. Тэгэхээр Завхан голтой холбогдох асуудал холуур өнгөрч буй хэмээн ойлгож болох нь.

Нөгөөтэйгүүр уурхайн эзэд хэн бэ гэх асуултыг нутгийнхан олон янзаар ярих аж. Баян-Айрагийн уурхайн эзэн нь хятад хүн тул 3000 хятад удахгүй орж ирж энэ уурхайд ажиллах тухай яриа ч гарчээ. Нэг ч хятад хүн Завханы уурхайд очихгүй гэдгийг тус уурхайн мэргэжилтнүүд учирласан юм.

Толгой компанийн талаар товч танилцуулахад “Керри QGX”-ын охин компани нь “Баян-Айраг эксплорэйшн”. Эдгээрийн толгой компани болох “Керри” групп нь “Kuok Brothers Limited” нэртэйгээр 1949 онд байгуулагдан цагаан будаа, элсэн чихэр, гурилын худалдаа эрхэлдэг байв. Улмаар 1952 оноос эхлэн үйл ажиллагаагаа өргөжүүлэн Сингапур, Тайланд, Индонез, Хонконгод салбараа нээснээр “Керри Холдинг” нэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, хөрөнгө оруулалт, ачаа тээвэр, агуулах, хими болон төмөрлөгийн үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл, үл уурхайн салбарт бизнес эрхэлж байна. Тус группын Монголд оруулсан хамгийн том хөрөнгө оруулалт гэвэл Их хотын зүрхэнд боссон “Сентрал тауэр” барилгыг нэрлэж болно. Керри QGX нь Баян-айрагаас гадна Тавантолгойд Баруун

наран төслийг хэрэгжүүлж буй. Керри группын эзэн Роберт Куок Малайз-Хятад гаралтай хүн бөгөөд Малайзын хамгийн баян эрд тооцогддог ажээ. Мөн Баян-Айрагт хамтран төсөл хэрэгжүүлж буй Монголын компани бол MCS групп юм.

“Уурхайн бэлтгэл ажлыг хангалттай түвшинд хийж чадахгүй байна” гэж “Баян-Айраг эксплорэйшн” компанийн орон нутаг хариуцсан мэргэжилтэн Б.Тайшир хэлэв. Учир нь орон нутгийн иргэдийн эсэргүүцлээс үүдэн тус уурхайн үйл ажиллагаа нэлээд хэдэн удаа зогсоход хүрч. Дөрвөлжин сум тэр дундаа Цогт бригадын иргэд энэ төслийг ихэд эсэргүүцэж жагсаал цуглаан хийж, үйл ажиллагааг нь хэдэн өдрөөр зогсоход хүргэдэг байна.

Баян-Айраг нь Цогт бригадын нутагт оршдог бөгөөд уурхайн нөлөөллийн бүсэд 30 гаруй малчин айлын өвөлжөө хамрагдаж байгаа нь асуудал болоод буй. Үнэхээрийн ч өвлийн тэсгим хүйтэнд Баян-Айраг уулын дулаан нөмөрт малтайгаа өнөтэй өвөлждөг малчдын хувьд том асуудал. Нөгөө талаар нутгийнхан байгаль нутгаа сэндийчүүлэхгүй, онгон байгалиар нь үр хойчдоо үлдээхийн тулд тэмцэж байна хэмээн тайлбарласан. Тухайлбал, Цогт бригадын малчин Л.Дашдэмбэрэл “Бэлчээр бууц, цаашлаад нутаг усныхаа төлөө бид тэмцэж байна. Малчид нутагтаа амьдрах баталгаагүй болж байна” гэсэн бол малчин П.Энхжаргал “Уурхайн мал, иргэдийн эрүүл тайван амьдралд сөргөөр нөлөөлөх нөлөөллийн эсрэг тэмцэж байна. Зөвхөн манай бригад бус сумаараа тэмцэх ёстой. Харин сумын удирдлагууд үүнийг нэгтгэж чадахгүй байна” хэмээн ярьсан.

Монгол Улсын бүх аймгийн нутагт уул уурхайн гар хүрч, байгаль эхийг эвдэж байгаа энэ үед завханчуудын хувьд анхны энэхүү том төслийг эсэргүүцэж тэмцэх нь бас зөв хэрэг. Тэмцлийн дүнд олон асуудлыг эл болгож, харилцан ярилцаж, ойлголцдог юм байна. Ер нь манайд үйл ажиллагаа явуулж буй уурхайн компаниуд орон нутгийн засаг захиргаа болоод, иргэдийн эсэргүүцэлтэй байнга тулдаг хүндрэлийн тухай ярьдаг шүү дээ. Хамгийн гол нь тэдэнтэй хэл үгээ ололцож, харилцан ашигтай хамтран ►

► ажиллах нь тухайн компанийн ухаалаг бодлого, соёлоос хамааралтай. Энэ нь нөгөө хариуцлагатай уул уурхайн хөгжил юм. Уурхай, засаг захиргаа, иргэдийн гурвалсан хамтын ажиллагаа, ойлголцол хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх тул Баян-Айраг дээр энэ асуудал л үгүйлэгдээд байх шиг. Нутгийн иргэдийн зүгээс том, жижиг олон санал тавьдаг, уурхайн хувьд заримыг нь хүлээж авахад боломгүй саналууд байх, дунд нь сумын захиргаа тодорхой шийдвэр гаргаж чадахгүй болж, Завхан аймгийн удирдлагууд орон нутгийн засаг захиргаа болоод иргэдтэй л зөвшилц гэсэн байр сууринаас ханддаг ийм л дүр зураг уурхайн эргэн тойронд үүсээд уджээ.

Уг нь бол “Баян-Айраг эксплорэйшн” нь үйл ажиллагаа явуулах бүхий л зөвшөөрлөө хуулийн дагуу авчихсан гэрээ хэлэлцээрээ байгуулчихсан компани аж. Одоо Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу сумын Засаг даргатай Хамтын ажиллагааны гэрээг байгуулах л үлдэж. Энэхүү гэрээ нь байгаль орчин, дэд бүтэц, ажлын байр

зэрэг гурван чиглэлээрх заалтууд байх ёстой. Гэрээний заалтууд дээр ялангуяа байгаль орчны үнэлгээ, нөхөн сэргээлтийг хэрхэн өндөр түвшинд хийх тухайд сумын удирдлагууд болоод Цогт бригадын иргэд ихэд анхаарч ажиллаж буй аж.

Харин Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар Хөрөнгө оруулалтын гэрээг төрийн байгууллага буюу Засаг даргатай байгуулах эрхгүй тул компанийн зүгээс энэхүү гэрээг аж ахуйн нэгж, эсвэл төрийн бус байгууллагатай хийх ёстой. Төрийн байгууллага бол уурхайгаас зохих татвараа аваад явах учраас уурхайгаас оруулах хөрөнгө оруулалт, нийгмийн чиглэлтэй хөрөнгийг аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх заалтыг тусгаж өгчээ.

Энэ хүрээнд “Баян-Айраг эксплорэйшн” компани Дөрвөлжин сум болон Цогт бригадын иргэдийг ТББ байгуулах, мөн нөхөрлөлүүдийг

үүсгэн байгуулж хамтран ажиллах санал гаргажээ. Тус бригадын хувьд өнөөдөр төрийн бус байгууллагыг байгуулсан бол одоо айл өрхүүд нөхөрлөлд хуваагдан өөрсдийнхөө хүрээнд айл өрхүүдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх санал санаачилга гаргаад явбал Баян-Айрагаас дэмжиж, хамтран ажиллах зөвшилцөлд хүрсэн байна. “Зөв шаардлага тавиад, манай компанитай бизнесийн түншлэлийн зарчмаар ажиллах тохиолдолд бид хүлээж авна шүү дээ” хэмээн “Баян-Айраг эксплорэйшн” компанийн гүйцэтгэх захирал Ю.Энхтүвшин хэлсэн.

Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд тухайн орон нутгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж, ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд ихээхэн ач тустай байдаг. Энэ үүднээс авч үзвэл “Баян-Айраг эксплорэйшн” нь үйл ажиллагаагаа эхэлсэн цагаас орон нутгийн хөгжилд 100 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулж, багагүй ажлыг хийжээ. Тухайлбал, сумын ►



Алт, зэс, мөнгө нуугдаж буй Баян-Айрагийн орд газар

► төвийн олон жилийн хур хогийн цэгийг орчин үеийн аргаар цэгцэлсэн байна. Мөн сумын төвд халуун ус барьж, жижиг цехүүд байгуулах иргэдийн боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, төмс ногоо тариалах зэрэг ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлжээ. Уурхайд ажиллаж буй 400-гаад ажилтнуудын 100 гаруй нь Дөрвөлжин сумын иргэд. “Бид ажлын байранд эхэлж тухайн орон нутгаас ажилтнууд авахыг чухалчилдаг” хэмээн компанийн удирдлагууд ярьж байсан. Цаашдаа уурхай ашиглалтад ороод бүтээгдэхүүнээ үйлдвэрлээд ирэхийн цагт орон нутгийн хөгжилд илүү бодитой, томоохон ажлууд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Нөгөө талаас харвал байгаль орчин бохирдож, сүйрэх, хүн малын амьдралд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс гарч ирдэг нь уул уурхайн сөрөг тал. Үүнийг өнөө үед компаниуд нөхөн сэргээлт, байгаль орчны үнэлгээний бодлогоор шийдэхийг хичээж ирсэн. Хамгийн гол нь иргэдийн зүгээс хяналт, хамтын ажиллагааг бий болгох нь хариуцлагатай ул уурхайн том хэсэг

нь юм. “Баян-Айраг эксплорэйшн” компанийн байгаль орчны бодлогыг сонирхвол олон улсын ISO14001 стандартаар явж байгаа аж. Энэ нь олон улсын түвшинд батлагдсан хамгийн дээд зэргийн стандарт юм байна. “Уурхайн нөхөн сэргээлтийг өндөр түвшинд хийж, байгаль орчны бодлого, хэрэгжилт талдаа хамгийн шилдэг компани болох зорилттой, мөн байгаль орчны асуудалд хариуцлагатай хандах зарчмаа тодорхойлсон” хэмээн тус компанийн Байгаль орчны асуудал хариуцсан захирал Дан Майклсен ярьсан. Уурхайн орчин тойронд ургах боломжтой олон модыг тарьж туршсанаар уурхайн хаалтын дараа сайн ургах мод, ургамлыг нөхөн сэргээлтэд ашиглахаар төлөвлөжээ. Тус компани нь уурхайн байгаль орчны бодлогоос гадна Дөрвөлжин сумыг цөлжилтөөс хамгаалсан ногоон зурвас байгуулах төдийгүй орон нутгийн олон иргэнийг сургалтад хамруулж, уурхай хаагдах үед нутгийн иргэдтэй хамтран мод ургамал тарих, нөхөн сэргээлт хийх, хяналт тавих зэргээр хамтран ажиллах зорилго агуулсан байна.

Сэтгүүлчийн үг

Нутгийн иргэдийн хувьд уурхайг бүрмөсөн зогсооно, хаана гэж тэмцээд хэрэггүй юм. Учир нь улс өмчөө мэдээд зөвшөөрлийг нь олгоод компани үйл ажиллагаагаа явуулаад өнөөг хүрчээ. Их хэмжээний мөнгө зарцуулчихаад хаяад гараад явах бизнес эрхлэгчид байхгүй шүү дээ. Харин сум орон нутгийн хөгжилд уурхайн ашгаас орж ирэх татварыг зөв ашиглах талд илүү анхаарал хандуулах ёстой. Их хэмжээний мөнгөн дүн шаардагдах төслүүдийг хэрэгжүүлэх, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, барилга орон сууц, замын хөгжлийг дэмжих, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр хамтран ажиллах нь зөв болов уу.

Дөрвөлжин сум нь Цогт, Буурал, Тавантолгой, Онц, Буга гэсэн таван багтай. Цогтоос бусад багийн иргэд Баян-Айрагийн үйл ажиллагаанд санал бодлоо идэвхтэй илэрхийлж, тэмцэлд оролцдоггүй. Цогт бригадынхан л өвөлжөөний нутгаа

мэдэг гэсэн байдлаар хандаж ирж. Үүнийг иргэд нь сумын удирдлагууд биднийг нэг гарт зангидаж, асуудалд хандаагүйгээс ийм байдал үүссэн гэж үзэх. Уг нь сумаараа нэгдээд нийлээд тус уурхайгаас сум орон нутгаа яаж хөгжүүлэх вэ, иргэдийнхээ амьдралыг хэрхэн яаж сайжруулах вэ, уурхайн үйл ажиллагааг хэрхэн дэмжиж, яаж хамтарч ажиллах болох вэ, нөхөн сэргээлт, байгаль орчны үнэлгээ, байгаль эхийг бага эвдэх, хяналт талд хэрхэн яаж оролцох вэ хэмээн тал бүрээс нь ярьж, санаа бодлоо хуваалцаж ажиллавал илүү үр дүнтэй, ажил хэрэгч саналууд гарах болов уу гэж харж явлаа.

Уурхай тойрсон элдэв яриа суманд байна. Асуудлыг буруу ойлгож, тэр чигээрээ явах хүмүүс сөрөг мэдээллийг нэлээд түгээж, бас асуудлыг ойлгосон ч дундуур нь ашиг олох, хэдэн төгрөг халааслахыг хүсэгчид бас явдаг бололтой юм. Бие биенээ уурхайтай холбон хардаж сэрдэх явдал нэлээд газар авч. Ийм байдлыг сумын засаг захиргааны удирдлагууд зохицуулж, ойлгуулах, харилцан ярилцах зарчмыг баримталж, иргэдээ нэгтгэх, зарим үед төрийн төмөр нүүрийг гаргах зэргээр арга хэмжээ авч ажиллах шаардлагатай юм байна гэсэн бодол төрснөө нуух юун.

Нөгөө талаар Баян-Айраг компани нутгийн иргэдэд мэдээллээ үнэн зөв, дэлгэрэнгүй өгч, иргэдийн зарим буруу ойлголтыг засаж залруулах, харилцан ойлголцох, ярилцах, чиглэлээр өмнөхөөс илүү хурдтай, сэтгэлтэй ажиллах хэрэгтэй юм болов уу. Бүх зүйлийг мөнгөөр харж, асуудлыг хүчээр шийдэж, сэтгэж, ярилцах нь өрөөсгөл гэдэг шүү дээ.

Эцэст нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, сум орон нутагтаа асуудлыг ашигтайгаар шийдвэрлэн сумын хөгжлийг эрчимжүүлэх чиглэлд орон нутгийнхан тэмцэж, байгаль дэлхийг бага сүйтгэж, эвдэлсэн газар нутгийн нөхөн сэргээлтийг стандартын түвшинд хийж, хөдөөгийн хөгжилд барьцтай, харагдахаар зүйл хийх нь компаниас шалтгаалдаг бол, энэ хоёрын дунд зохицуулалтын үүрэг гүйцэтгэж, хувийн хэвшлийг ч, орон нутгаа ч, иргэдээ ч хамгаалж ажиллах нь нутгийн засаг захиргаанаас бас шалтгаална гэдгийг хэлэхийг хүслээ. ■



ЗОЧИН

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖИЛ БЭЛЭГ БАЙГААГҮЙ

Б.ЭНХЦЭЦЭГ

Швейцарийн Элчин сайдын яамны Хамтын ажиллагааны газрын Суурин төлөөлөгч, Консулын хэлтсийн Ерөнхий консул Феликс Феллманн Монгол Улсад ажиллаж, амьдраад зургаан жил болж байгаа бөгөөд удахгүй нутаг буцахаар зэхэж буй. Тэрбээр Монголд байх хугацаандаа хоёр улсын хамтарсан олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гар бие оролцож, Монголын дийлэнх аймаг сумд зочлон, ард иргэдтэй хамтарч ажиллажээ. Ирэх жил манай хоёр улсын дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохионо. Мөн Швейцарь, Монголын хамтын ажиллагаа улам хөгжиж байгаатай холбогдуулан Монгол дахь Швейцарийн хөгжлийн агентлаг 2013-2016 онд хэрэгжүүлэх Хамтын ажиллагааны шинэ стратегиа баталжээ. Үүнтэй холбогдуулан Ерөнхий консул Феликс Феллманнтай ярилцсан юм.



-Хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа өнөөдөр ямар түвшинд явж байгаа талаар нэн тэргүүнд ярихгүй юу?

-Манай хоёр улс дипломат харилцаа тогтоогоод өдгөө 49 жил болжээ. Хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг бид 2004 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Үүнээс өмнө 2000 онд Хүмүүнлэгийн тусламжийн зарим оролцоог бий болгосон байсан. Швейцарийн сангийн санхүүжилттэй Хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Монгол Улстай өнгөрсөн есөн жилийн хугацаанд хамтарч ажиллалаа. Манай хоёр орон мал аж ахуй, далайд гарцгүй, хүчирхэг хөршүүдээр

хүрээлэгддэг гэхчлэн газар нутаг, соёлын хувьд нэлээд төстэй. Тиймээс бид суралцах, хуваалцах зүйл ихтэй. Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд Монголын Засгийн газар, нийгмийн дэмжлэгийг сонсож тэргүүн зорилгуудаа тодорхойлсон. Анх хүнсний ногоо тэр дундаа дотооддоо төмсний хэрэгцээгээ бүрэн хангаж, ▶

▶ гарцаа дээшлүүлэхэд туслаач гэж хүссэн учир бид үүнээс ажлаа эхэлсэн. Хоёрдугаарт, малчидтай хамтарч, эрүүл мэнд, бэлчээр, тэжээлийн асуудлыг түлхүү анхаарч хагас нүүдлийн фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд туслах санал байсан. Бидний хувьд энэ асуудлын хүрээнд одоо ч ажиллаж байгаа. Гуравдугаарт, Монголд байсан 50-100 мянган хууль бус бичил уурхайчны ажиллах орчин, байгаль орчин, эрүүл мэнд, химийн бодис хэрэглэж буйтай холбогдсон асуудлыг цэгцлэх байв. Тэд өнөөдөр хуулийн дагуу үйл ажиллагаа эрхлэх боломжтой болсон. Үүнээс гадна өөр олон төсөл бий. Жил бүр хоёр талын хамтын ажиллагааны төслүүдэд бид 15-20 сая ам.долларыг зарцуулж, олон зуун хүнийг ажиллуулдаг.

-Хэдийгээр хоёр орны эдийн засаг, худалдаа өсч буй ч хурд, хэмжээ чамлалттай байгаа. Үүнийг хэрхэн сайжруулж болох вэ?

-Бидний хувьд худалдааны асуудал дээр ажилладаггүй. Гэвч холбогдох Засгийн газрын агентлаг үүнд анхаарч байна. МҮХАҮТ-тай холбоотой байдаг. Энэ сэдвийг сөхөх бүрт ямар бүтээгдэхүүн санал болгохыг асуудаг. Европын зах зээл нэлээд өндөр шалгууртай учир зөвхөн өндөр чанартай бүтээгдэхүүн л нэвтэрдэг. Одоогоор зах зээлд хүлээн зөвшөөрөгдөх бэлэн бүтээгдэхүүн нь Монголын хувьд архи. Тэр дундаа шилэн дээрээ Чингисийн зураг, нэртэй архи нь түүхийн хувьд олонд танил, мартагдахааргүй учир онцлог. Бусад төрлийн бүтээгдэхүүн ч байж болно. Тухайбал, өндөр чанарын ноолууран бүтээгдэхүүн. Европчууд тансаг чамин хэрэглээнд дуртай тул их мөнгө төлдөг. Хэрэв Монгол ноолуураа хангалттай хэмжээнд боловсруулж чадвал, Хойд Америк, Европ, Япон руу нэмүү өртөг шингэсэн өндөр үнэтэй бүтээгдэхүүн гаргах боломжтой. Дараагийн сонирхож буй салбар нь аялал жуулчлал. Массын бус адал явдалт аялал жуулчлал. Үзэсгэлэнт байгаль, нөхөрсөг иргэдтэй Монгол оронд бусдыг татах хүч бий.

-Швейцарийн хамтын ажиллагааны 2007-2010 оны хөтөлбөрийн үр дүн юу байсан бол?

Мөн 2013-2016 онд хэрэгжүүлэхээр баталсан стратегийн шинэ хөтөлбөрөөс хүлээж буй гол үр дүн юу вэ?

-Бидний гаргасан шинэ стратеги өмнөхөөсөө нэлээд өөр. Монгол буурай бус дундаж орлоготой орон болсон учир бид арай өөр талаас хамтарч ажиллахаар анхаарч эхэлсэнд гол ялгаа нь оршиж буй. Монгол Улс харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд илүү идэвхтэй оролцохыг хүсэж байна. Шинэ стратегийн хүрээнд бид дангаараа ямар нэг санхүүжилт хийхгүй. Энэ зөвхөн бидний хүсэл бус хоёр талын санаачилга. Монгол Улсын Ерөнхийлөгч хэлэхдээ "Бид жолооны ард суух чадвартай болсон тул төслүүдийн санхүүжилтийг хамтран хийж чадна" хэмээсэн.

Шинэ стратегийн хөтөлбөрийн хүрээнд монголчуудад тулгамдаад буй бодлогын гурван асуудлыг онцолж буй. *Нэгдүгээрт*, Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал. Бид энэ салбарт өмнө нь ажиллаж байсан ч энэ удаад мал аж ахуй, хүнсний ногоонд түлхүү анхаарна. *Хоёрдугаарт*, мэргэжил олгох тусгай сургалт, дадлагын хичээл. *Гуравдугаарт* төр, орон нутгийн захиргаа, иргэний нийгмийн шинэчлэл. Үүний гол зорилго нь иргэдийн хөгжил дэвшлээ удирдах, санхүүжүүлэх эрхийг нэмэгдүүлэх юм. Аймаг, сумдын захиргаанд нэлээд их төсөв очиж буй. Үүнийг захиран зарцуулахад бэлдэх нь мөн бидний ажил. Түүнчлэн Монголын иргэний нийгмийн оролцоог чадавхжуулахад анхаарна. Эдгээр нь хөтөлбөрт өмнө нь тусгаж байгаагүй ажлууд.

Хуучин стратегийн хөтөлбөрт бид нийт 50 мянган малчинтай хамтран ажилласан. Тэд өнөөдөр газар орноо удаан хугацаанд тогтвортойгоор хадгалах удирдлагын системийг хэрэгжүүлээд явж байна. Мөн Монгол өнөөдөр хоёр хөршөөсөө импортлох шаардлагагүйгээр хэрэгцээнээсээ давсан төмс хураадаг болчихлоо. Бид Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хэрэгжүүлж буй өгөөжтэй, ил тод нэг цонхны төрийн үйлчилгээ хөтөлбөрийг дэмжин ажилласаар ирсэн. Өнөөдөр хүмүүс

нэг газраас 5-10 минутын дотор төрийн үйлчилгээг тогтсон төлбөртэйгээр авах боломжтой болсон. Мөн бидний зүгээс бичил уурхайн үйл ажиллагааг хуулинд тусгуулж, хорт нөлөө ихтэй мөнгөн ус, цианит ашиглалгүйгээр алт олборлох тал дээр нэлээд хүчин чармайлт гаргасан.

-Швейцарь улс Монголтой адилхан далайд гарцгүй, цөөн хүн амтай. Гэсэн ч эдийн засгийн тогтвортой үзүүлэлттэй хөгжингүй орнуудын нэг. Тэгвэл геополитикийн сул тал, ажиллах хүчний хомсдолын асуудалд ямар бодлого барьдаг вэ?

-Үнэндээ байгалийн баялаг талаас нь харвал бид юу ч үгүй ядуу улс. Швейцарийг яаж ч судлаад ашигт малтмал олоогүй. Энэ л биднийг өнөөгийн хөгжилд хүргэсэн гол хөшүүрэг. Бидэнд байгалийн баялаг заяагаагүй ч байгалийн гоо үзэсгэлэнг харамгүй хайрласан. Энэ л бий. Дэлхийн II дайны дараа Швейцарь ядуу орон байсан. Тэр үед нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулахаар шийдсэн. Өөрсдийн худалдаж авч буй бүтээгдэхүүндээ нэмүү өртөг шингээнэ гэсэн үг.

Хэрвээ энэ замыг сонгоогүй бол өнөөдөр бид Европын ядуу орон хэвээрээ байх байсан. Дотоодын компаниуд гаднаас төмрийн хүдэр, түүхийн какао зэрэг бүтээгдэхүүн авч машин техник, шоколад тэргүүтэй нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Ихэнх бүтээгдэхүүнийхээ материалыг гаднаас авч, боловсруулан эцсийн бүтээгдэхүүн болгодог. Үүнээс үүдэн боловсролыг түлхүүр гэж үзэн, өндөр чадвартай мэргэжилтнүүдээ бэлтгэж эхэлсэн. Өнөөдөр манай улс санхүү, даатгалын мэргэжилтнүүд олонтой ч өндөр чанартай машин техник, эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг. Энэ бүгдэд нэмүү өртөг шингэсэн. Тиймээс манай улсын хөгжил бэлэг байгаагүй.

-Швейцарь улсын онцлом амжилт, давуу талыг нэрлэхгүй юу?

-Миний хувьд Швейцарийн боловсролын систем гэж бодож байна. Өндөр боловсрол олгодогт бус байр сууриас үл хамаарсан боловсролын ▶

Үнэндээ байгалийн баялаг талаас нь харвал бид юу ч үгүй ядуу улс. Швейцарийг яаж ч судлаад ашигт малтмал олоогүй. Энэ л биднийг өнөөгийн хөгжилд хүргэсэн гол хөшүүрэг

► системд гол учир байгаа юм. Манай боловсролын систем хөдөлмөрийн зах зээлд мэргэжилтэй хүмүүс бэлтгэдэг. Тиймээс Швейцарийн нийт иргэдийн ердөө 25 хувь нь дээд боловсролтой бол үлдсэн нь зах зээлд өндөр эрэлттэй мэргэжлийн ур чадваруудыг эзэмшсэн байдаг. Тухайлбал, мужаан, барилгачин, авто механикч, цахилгаанчин, зэрэг хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлттэй мэргэжлийг практик дадлагаар эзэмшүүлдэг. Европын ажилгүйдлийн нийт түвшин 15-20 хувь. Эдгээрийн дийлэнх нь 25-30 насны залуус байна. Ажилгүйдлийн түвшин Испанид 15, Францад 30, Германд ойролцоогоор 15 хувь байгаа бол манай улсад тавхан хувь байна. Ийм доогуур үзүүлэлттэй байгаа нь ихэнх иргэд мэргэжлийн ур чадвартай байдгаас үүдэлтэй. Эрэлтдээ нийцүүлэн хүмүүсээ сургаж, чадавхжуулж байна.

-Олон улс хүлээн зөвшөөрсөн брэнд бүтээгдэхүүнүүдтэй болох талаар монголчууд их ярих болсон. “Swatch”, “Nestle” хэмээх дэлхийд тэргүүлэгч Швейцарь брэндүүд зөвхөн компаниа төдийгүй улсаа бүрэн илэрхийлдэг. Тэгвэл эдгээр брэнд бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг өндөрт өргөдөг хүчин зүйлс нь юу вэ?

-Манай улсын бүтээгдэхүүн олон улсын эрэлтийг дагадаг учир дэлхийд алдартай байдаг. Дэлхий даяараа л шоколад идэхийг хүсдэг. Тэр дундаа хамгийн сайныг нь. Тиймээс Швейцарь хамгийн сайныг нь хийдэг. Цагны хувьд ч адилхан. Чанартай цагны эрэлт өндөр байдаг. Тиймээс бид үүнд хариу үйлдэл үзүүлж буй. Энэ бүхэн үйлдвэрлэгч компани төдийгүй Швейцарийн нэр хүндтэй холбоотой тул итгэл даах ажилчдыг л авдаг. Өндөр чанартай бүтээгдэхүүнийг зөвхөн шинийг санаачлах, сахилга бат өндөртэй систем бүрдүүлсний үндсэнд л үйлдвэрлэж чадна. Энэ бол бизнес.

Брэндингийн тухайд АНУ тэргүүлэгч. Гэвч Швейцарь жижиг орон гэлтгүй дээгүүр бичигддэг. Хэдхэн жилийн дотор брэндинг хийнэ гэж байхгүй. Бидний хувьд өнгөрсөн 200, 300 жилийн турш

брэндингээ хийсээр ирсэн. Энэ бол урт хугацааны бодлого. Цаг, зарим хүнсний бүтээгдэхүүн, аялал жуулчлалын салбарт бид үргэлж байсаар ирсэн. Бүтээгдэхүүнээ өөрчилдөггүй ч хэрэглэгчдийнхээ сонирхол, эрэлтэнд тулгуурлан үргэлж сайжруулдаг. Учир нь швейцарьчууд бүтээгдэхүүнээ өөрчилбөл үнэ цэнээ алдана. Дэлхий тэр аяараа тодорхой бүтээгдэхүүнд дассан байдаг бөгөөд энэ нь манай улсыг эргэх холбоонд оруулдаг. Тухайлбал, Монголын хувьд ноолуур нь сайн холбоос болох ч ажил хэрэг болгохын тулд эрэлтэд нийцсэн өндөр чанартай, итгэл даахуйц байх ёстой.

-Танай орны бизнес эрхлэгчид Монголын эдийн засгийн ямар салбаруудыг сонирхож байна вэ?

-Бид барилга, дулаалга, эрчим хүчний хэмнэлтийн тал дээр түлхүү сонирхож байгаа. Хоёрдугаарт, уул уурхайн худалдаа. Үүнд машин техник, даатгал багтана. Томоохон уул уурхайн компаниудад санхүүгийн болон даатгалын нүсэр систем хэрэгтэй байдаг. Мөн эмнэлгийн үйлчилгээг ихээхэн сонирхож буйгаас гадна худалдааны тодорхой сонирхлууд бий.

-Монголчуудын хувьд Швейцарийн виз авахын тулд Бээжинг зорих хэрэг гардаг. Танай улсын зүгээс Монголд Элчин сайдын яамтай болох эс бөгөөс визний асуудлыг хөнгөвчлөх тал дээр ойрын үед төлөвлөсөн ажил бий юү?

-Бид визний асуудлыг хөнгөвчлөхөөр ажиллаж байгаа. Улс бүрт Элчин сайдын яамтай байх нь өртөг өндөртэй учир бид зөвхөн томоохон улсуудад Элчинтэй. Зөвхөн монголчуудын хувьд бус бидэнд ч энэ нь толгойны өвчин. Манай улс Шенгений визний систем бүхий Европын Холбооны нэг хэсэг учраас монголчууд Бээжин рүү явах шаардлагатай байгаа юм. Шенгенийн систем виз хүсэгчдийг Элчин сайдын яаманд заавал өөрийн биеэр ирэхийг шаарддаг. ■

МОНГОЛ БА АВСТРИ-АМЖИЛТТАЙ, ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ



Австри болон Монгол Улсын хувьд 2013 он бол онцгой жил юм. Учир нь манай хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиож байна. Анх 1963 оны зургаадугаар сарын 30-нд дипломат харилцаа тогтоох гэрээнд талууд гарын үсэг зурсан түүхтэй. Түүнээс хойш хоёр улсын харилцаа улс төрийн хувьд дэвшилтэт шатанд гараад зогсохгүй эдийн засгийн хувьд ч дотно харилцаатай болжээ. Хоёр талт худалдаа 2012 оны байдлаар 19 сая еврогоос давсан үзүүлэлттэй байгаа нь манай хоёр улсын хоорондох худалдаанд гарсан томоохон амжилт билээ.

Он гарсаар эхний гурван сард Австриас Монгол руу хийсэн экспорт 145 хувь, Австри Монголоос авсан импорт 186 хувиар тус тус нэмэгджээ. Ялангуяа хоёр улсын худалдааны төрөлжилт тогтвортой өсч байгааг харахад маш таатай байна. Гэтэл тавхан жилийн өмнө Монголоос Австри руу чиглэсэн экспорт зөвхөн ноолууран бүтээгдэхүүнээр хязгаарлагддаг байсан бол өнөөдөр малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн болон төрөл бүрийн оёмол бүтээгдэхүүнээр төрөлжжээ. Харин

Австралиас Монгол руу хийж буй экспортод автомашин, уул уурхайн болон бусад тоног төхөөрөмж зэрэг Австрийн өндөр технологи бүхий бараа, бүтээгдэхүүн статистикийг тэргүүлж байна. Зөвхөн арван жилийн дотор Монгол руу чиглэсэн Австрийн экспорт дөрөв дахин нэмэгдсэн байгаа юм.

Хоёр талт худалдаа хурдацтай хөгжиж байгаа нь манай хоёр орны эдийн засаг төгс зохицож буй хэрэг. Монголд чухалд тооцогдох салбаруудын зах зээл болон технологийн талбарт дэлхийд тэргүүлэгчдийн дунд Австрийн компаниуд ордог. Уул уурхайн тоног төхөөрөмж, өндөр чадвартай машин техник, дэд бүтэц, эрүүл мэнд, боловсрол зэрэг нь манай хоёр орны компаниудын амжилттай хамтран ажиллах боломжтой салбарын нэгээхэн хэсэг төдий. Манай компаниуд салбарын шийдлүүдийг уян хатан, хэрэглэгчид тохиромжтой байдлаар хангаж өгснөөр өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хамгийн орчин үеийн технологи гаргах талд мөн нэр хүндтэй. Манай хоёр оронд байдаг нийтлэг бас нэг зүйл бол байгаль орчноо хайрлан хүндэтгэдэгт оршино. Австри, Монголын хот, суурин газрууд амьдрахад хамгийн таатай хотуудын тоонд багтдаг. Байгаль орчинтойгоо зохицсон технологи болон бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд Австрийн Засгийн газар, аж үйлдвэрийн салбар хүчин чармайлтаа тавин ажиллаж байна. Монгол Улс эдийн засгийн өндөр өсөлт, хотжилттой нүүр тулж байгаагийн хувьд эдийн засгийн өсөлт болон тогтвортой хөгжлийн тэнцвэрт зөв байдалд хүрснээр Австри улс Монголын найдвартай, шинийг санаачлагч түнш байх боломж бүрдэнэ.

Өнгөрсөн 50 жилд бид хамтдаа бүтээсэн ололт, амжилт нь гэрэлт ирээдүйн эхлэл гэдэгт миний бие итгэл төгс байна. Ойрын жилүүдэд хоёр улсын компаниудын харилцан хөрөнгө оруулалт нэмэгдэж, худалдааны хамтын ажиллагаа улам гүнзгийрч, улмаар худалдааны бүтэц төрөлжихийг бид харах болно. Хоёр тал 2011 онд гарын үсэг зурсан хөнгөлөлттэй зээлийн гэрээ нь энэ чиглэлээр хийсэн чухал алхам болсон. Австрийн компаниуд Монголын зах зээлийг хэдийнэ сонирхох болжээ. Эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон байгаль орчны салбарт хэрэгжүүлэх олон төсөл хэлэлцээрийн шатанд явж байгаа бөгөөд тэдгээр төсөл, хөтөлбөр бидний харилцан ашигтай хөгжил, нөхөрлөлийг урагшаа татах болно.

Оскар Андеснер
Худалдааны төлөөлөгч

БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

“APPLE”-ЫН АРВАН НУУЦ

Х.ХУЛАН

Жил бүр “Apple” компанийн Калифорнид зохион байгуулдаг “World Wide Developers Conference” (WWDC) чуулга уулзалтын үеэр шинэ бүтээгдэхүүн танилцуулахаас гадна илтгэлийн шинэчлэлт аргыг бодит жишээгээр үзүүлдэг билээ. Тус компанийн төлөөлөгч Тим Кукийн бэлтгэсэн илтгэлд “Форбес” сэтгүүл дараах дүн шинжилгээ хийснийг толилуулж байна.

Нэг хуудас- нэг санаа

Танилцуулах гэж байгаа бүх санаагаа нэг хуудсанд багтаах гэж оролдсоны хэрэггүй. Энэ зарчим тоон мэдээлэлд ч хамааралтай. Тухайлбал, дараах текстийг Та нэг хуудсанд оруулах байсан уу? Текст: Бид бүртгэлтэй зургаан сая программ боловсруулагчтай хамтарч ажилладаг. Энэ шоунд оролцох бүх тасалбарыг 71 секундэд борлуулав. Тим Кук тус агуулгыг гурван хуудсанд буулгажээ. Эхний хуудсанд “зургаан сая”, удаахад “71” секунд гэж бичсэн байна. Гурав дахь дээр нь “Борлуулав” гэжээ. Өөрөөр хэлбэл, Таны хэлэх гэж байгаа мэдээлэлд тоо нь чухал байвал тэрнийгээ бүтэн хуудсан дээр онцлоорой.

Статистикийг дүрслэхүй

Тим Кук илтгэлийнхээ эхэнд “iPhone” утас хэрэглэгчид нийт 50 сая аппликэйшн татаж авсан тухай ярьсан. Гэхдээ 50 сая гэсэн тоог хэрхэн бичих дээр хүртэл ач холбогдол өгсөн аж. Илтгэлийн дизайнер 50 сая гэх бус 50 000 000 гэж бүх тэгийг бичсэн нь үзэгчдэд улам их сэтгэгдэл төрүүлсэн байна. Түүнчлэн тоо бүрийг “Apple store” доторх аппликэйшны дүрсээр бүтээжээ. Учир нь сонирхолтой чимэглэл бүхий статистик хүний ой тойнд амархан буудаг нь батлагдсан юм.

Цэгэн болон суман илтгэлээс татгалз

“Apple”-ын илтгэлийн ганц ч хуудсанд тоочсон цэг, сум тавиагүй нь анхаарууштай. Цэг эсвэл сумаар мэдээллээ жагсаах арга төдийлөн үр дүнтэй биш. Цэг, сум хэт том харагдахаас гадна илтгэл сонсогч илтгэгчид биш, сумын ард бичсэн текст уншихад илүү их анхаарал хандуулахад хүрдэг. Ихэнх хүн унших, сонсоход зэрэг төвлөрч чаддаггүй бөгөөд бүх мэдээллийг тогтооход бэрхшээлтэй болдог.

Илтгэлдээ бусдыг оролцуул

Компанийн удирдлагууд ихэнх тохиолдолд илтгэлээ өөрсдөө эхнээс нь дуустал ярих хэрэгтэй гэж үздэг. Тим Кук илтгэлдээ компанийнхаа удирдагч, дизайнер, хамтран ажиллагч, түнш, программ боловсруулагч нарыг мөн оролцуулсан байна. Жишээлбэл, программ хангамжийн дэд тэргүүн Крейг Федериги хоёр удаа тайзан дээр гарч ирсэн. Дизайнер Жонни Айв iOS7 загварын мөн чанарыг өөрөө тайлбарласан байна.

Илтгэх цаг “10” минут

Вашингоны Их сургуулийн судлаач Дон Медины үзэж буйгаар тухайн илтгэгчийн ярих үр чадвар үнэхээр сайн байсан ч сонсогчид 10 минутын дараа ядардаг болохыг ▶▶



- ▶ баталжээ. Тим Кукийн хувьд илтгэлээ 10 минутаас хэзээ ч хэтрүүлж байгаагүй гэнэ. Тэрбээр сонсогчдын анхаарлыг татахын тулд “бяцхан завсарлага”-ын аргыг хэрэглэдэг. Илтгэлдээ бусдыг урьж оролцуулахаас гадна видео бичлэг, зурагтай тайлбарыг мөн өргөнөөр ашигладаг.

Сэтгэлээсээ ханд

“Apple”-ын олон улсын маркетинг хариуцсан дэд ерөнхийлөгч Фил Шиллер шинэ нөутбук “Mac Pro”-г танилцуулж байхдаа сонсогчдоос нижигнэсэн алга танилтыг хүлээн авчээ. Шинэчлэлгүй бүтээгдэхүүн зах зээлд гаргасан гэсэн шүүмжлэлд Шиллер: “Чөтгөр аваг, үүнээс илүү шинэчлэл хаана байна” хэмээн хошигножээ. Илтгэгчийн ярьж байгаа сэдэвтээ чин сэтгэлээсээ хандах байдал бүгдэд таалагдах нь дамжиггүй юм.

Twitter-т бичдэгийн адил ярь

Мэдээллийн хамгийн үр ашигтай техникт “Жиргээ” буюу Twitter-ээр мэдээлэл түгээх юм. Та ямар ч бүтээгдэхүүн гаргасан 140 тэмдэгтэд багтааж мэдээллээ бичдэг эл арга нэлээд шалгарсанд тооцогддог. “Apple” компанийн iOS7 загварын танилцуулгыг мөн л ийм зарчмаар толилуулсан. Тим Кук хоёр удаа “iOS7 бол манай компанийн хамгийн шинэлэг, дэвшилтэт загвар мөн” гэсэн. Үүнийг “Жиргээнд” ингэж илэрхийлсэн байлаа:

@Mashable: Apple компани хамгийн шинэлэг iOS7 загварыг нэвтрүүлээ

@HuffPostTech: Та бүхэн “Apple” компанийн хамгийн шинэлэг загвар болох iOS7-д анхаарлаа хандуулна уу

@USATODAY: Тим Кук iOS7 загварыг анхны iPhone гарснаас хойшхи хамгийн шинэлэг гэж хэллээ

Twitter-ээр мэдээлэл түгээх зарчим ямагт үйлчилнэ гэдгийг санаж явахад илүүдэхгүй.



Турш, турш, бас дахин турш

“Apple”-аас гаргаж буй бүтээгдэхүүнийг танилцуулсан 20 минутын илтгэлд 250 хүртэлх цаг зарцуулдаг тухай Та мэдэх үү? Илтгэлийн танилцуулгын зохиомж, текстийн агуулгыг гаргах, тайзан дээр танилцуулах бэлтгэлд энэхүү цаг хугацааг зарцуулдаг аж. Хамгийн гол нь илтгэгч бүр өөрийн хийдэг ажлаа тайлагнасан танилцуулга бэлддэг тул үнэн зөв, бодитой байдаг.

Ажилтнуудаа хүндэл

Нэг баг болж ажиллаж буй хамтран ажиллагсдаа харилцан хүндлэл үзүүлэхээ мартаж болохгүй. Тим Кук илтгэл бүрдээ ажлынхандаа талархсан үг хандаж хэлдэг уламжлалтай. Түүний хэлсэн үгнээс ишлээ: “Та бүхний харж байгаа энэ бүтээгдэхүүнийг бүтээлцсэн “Apple” компанийн ажилчдаа талархаж байна. Би хамгийн авьяаслаг, бүтээлч хамт олонтой гар нийлүүлэн ажилласандаа баярладаг. Дашрамд дурдахад та бүхэнтэйгээ хамтран ажиллахад надад таатай байдаг шүү” гэжээ.

Хамтран ажиллагсдаа талархлаа ойр ойрхон илэрхийлж зуршина уу.

Илтгэлийг нийтийн хүртээл болго

“Apple” компани хоёр цаг үргэлжилсэн видео хурлаа өөрийн цахим хуудсандаа байршуулсан. Эл илтгэл байгууллагын брэнд, маркетингийн бодлогын салшгүй хэсэг нь болжээ. Иймд Та өөрийн байгууллагын танилцуулгаа сайтдаа оруулж байгаарай. ■

MISSHA

Golden Snowflake Eye Cream



Missha нэрийн дэлгүүр Монголд албан ёсоор
2013.07.20-нд нээгдэнэ.

УИД-ийн зүүн талд Missha нэрийн дэлгүүр;
3-р хороолол АРЕХ их дэлгүүрийн 1 давхар

Утас: 70113234, 99060318

<http://facebook.com/missha.mgl>

Цэвэр алтны хорьцтой зовхины тос

Уг тос нь найрлагандаа цэвэр алт, зэрлэг хүн орхоодой, бугын цусан эвэр агуулсан тансаг зэрэглэлийн зовхины тос юм. Уламжлалт аргаар бэлтгэдэг тул зовхины хөхөрч, суларсан арьсыг чангалах, үрчлээсийг арилгах үйлчилгээтэй.

Бүтээгдэхүүний зориулалт: Зовхийг гадны нөлөөллөөс хамгаалах зургаан давхар хамгаалалт бүхий, үрчлээний эсрэг, арьс цайруулах үйлчилгээтэй бүтээгдэхүүн юм.

Орц найрлагын тухай:

Дугаар
1

Үрчлээг арилгана



Зэрлэг хүн орхоодой нь хуурайшиж гэтмсэн арьсыг сэргээж, эрүүл толигор болгоно.

Дугаар
2

Доод зовхины хөхрөлт, сүүдрийг арилгана



Цэвэр алт, хүн орхоодой, бугийн цусан эвэр зэргийн нэгдэл нь хөхөрч, сүүдэрлэсэн болон хавагнасан арьсыг эрүүлжүүлдэг.

Дугаар
3

Зовхины суларсан арьсыг чангална



Дээрх идэвхитэй найрлагыг уламжлалт аргаар гаргаж авснаар унжиж суларсан зовхийг чангалах үйлчилгээ үзүүлж арьсыг залуужуулна.

Зовхины тосыг дараах байдлаар түрхэж хэрэглэвэл ИЛҮҮ ҮР ДҮНТЭЙ

ТА ТОСОО ДАРААХ ЗААВРЫН ДАГУУ ТҮРХЭЭРЭЙ



1. Нүдээ аниад чамархай хэсгийг дунд хуруугаараа 3-4 удаа хөнгөхөн дугуйруулна.




2. Доод зовхинд дотроос гадагш чиглэлтэй түрхэж өгсний дараа долоовор хуруугаар товшиж өгнө.



3. Долоовор хуруугаараа доод зовхины дотроос гадна талруу товших хөдөлгөөнөөр давтана.



4. Зовхины тосоо нүдний дээд зовхинд жигд түрхэж, өгсний дараа хуруугаар товшино.



5. Дээд зовхины дотроос гадна чиглэлд 3секундын турш дарж өгнө.



6. Дээрх дасгалыг хийсний дараа долоовор хуруугаараа хөнгөн дарж байвал тосны үйлчилгээ илүү үр дүнтэй болно.

MISSHA cosmetics